

МОНГОЛ УЛСЫН «ГУРАВДАГЧ» ГҮРНҮҮДЭД ХАНДСАН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА: ХХ ЗУУНЫ ТЭРГҮҮН ХАГАСТ

Д.Уламбаяр¹

1. Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын үе

«Гуравдагч хөрш»-ийн тухай үзэл баримтлал шинэ тутам гарч ирсэн үзэл санаа биш юм. Монгол Улс түүхэндээ «гуравдагч хөрш»-өө эрж хайж байсан цаг үе ХХ зууны эхний хориод жилд холбогддог бөгөөд харин цэгцтэй ойлгох, бодлогын түвшинд томъёолох, боловсруулах талаар оролдлого хийж байгаагүй нь мэдээж.

Геополитикийн үүднээс шинжилж үзвэл Монгол шиг цэрэг-улс төр, эдийн засгийн үлэмж чадавхтай, дэлхийд хамгийн олон хүн амтай, мөн дэлхийд хамгийн том газар нутагтай, цөмийн зэвсэгтэй хоёр их гүрний дунд орших, далайд гарцгүй, түүнчлэн монгол угсаатнаар хүрээлэгдсэн өвөрмөц газарзүй-орон зайн байршилтай орон байхгүй юм. Олон зуун жилийн туршид геополитикийн хүрээгээ ямагт тэлж, дэлхийн бодлогод нөлөөлсөөр ирсэн хоёр хөрш Монголчуудын түүхэн хөгжлийн тодорхой үе шатанд олон талаараа шууд болон дам нөлөө үзүүлж, эгзэгтэй үед Монголын хувь заяаг тусдаа хийгээд хамсан нийлж байгаад шийдвэрлэж байсан нь түүхэн үнэн билээ.

¹ Д.Уламбаяр. Др.проф. ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал

Нийт монголчуудыг нэгэн улс гэрт нэгтгэх зорилгын дор байгуулагдсан Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улс нь газар нутгийн хувьд Азийн томоохон улсуудын тоонд орж байлаа. Ийм өргөн уудам газар нутагтай, байгалийн баялаг нь судлагдаагүй боловч нөөц ихтэй, жижиг зах зээлийн багтаамжтай ч, цэрэг-стратегийн талаар чухал ач холбогдолтой Монголын хувь заяаны асуудалд умард, өмнөд хоёр хөршөөр үл барам Франц, Япон, Англи, АНУ, Герман зэрэг гүрнүүд өөр өөрсдийн ашиг сонирхлын үүднээс хандаж байв

1911 оны тусгаар тогтнолын сэргэлтийн дараа Монголын удирдагчид хоёр хөршөөсөө гадна «гуравдагч хөрш»-тэй харилцаа тогтоохыг чинхүү эрмэлзэж байсан нь гадаад улс төрийн бодлогын чухал чиг шугам байжээ. Энэ нь юуны өмнө Өрнө, Дорны гүрнүүдээр тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, улмаар тэдгээр орнуудтай худалдааны харилцаа холбоо тогтоох, Өвөрлөгч нутгийг Халхад нэгтгэх замаар Монгол үндэстний улс төрийн нэгдлийг хангах, түүнийгээ бататгах үндэсний эрх ашиг хийгээд үндэсний аюулгүй байдалтай ямагт холбогдож байв.

Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын гадаад бодлого, дипломатын түүхэнд 1912 оны 10 дугаар сард 21-нд (шинэ тооллоор 11 дүгээр сарын 3) нийслэл Хүрээнд Монгол-Оросын Найрамдлын гэрээ бичиг болон Худалдааны Протоколд гарын үсэг зурсан нь үлэмжийн ач холбогдолтой түүхэн үйл явдал болжээ. Сайхь гэрээ бичиг ёсоор Хаант Орос Монгол Улс болон түүний Засгийн газрыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн төдийгүй цаашид энэ гэрээ бичиг Монголын төр улсын бүрэн эрхт байдлыг баталгаажуулах олон улсын эрхзүйн үндэс суурийг нь тавьжээ. Монгол Улс Оросын эзэнт гүрэнтэй гэрээ бичиг байгуулсан нь тухайн үед Бээжингийн засаг баригчдаас Монголын талаар явуулж байсан консерватив башир бодлогод том цохилт болж, Хятадын Засгийн газар Хаант Оростой Монголын тухайд асуудлаар яриа хэлэлцээ хийх зайлшгүй нөхцлийг нэгэнт буй болгожээ. Дурдсан гэрээ бичгийг байгуулсан явдал Монгол, Хятад хоёр улсын урьд өмнөх харилцааны status quo-г дуусгавар болгосон төдийгүй, мөн шинэ тулгар Монгол Улсын хувьд дэлхийн улс гүрнүүдтэй энэ тэнцүү харилцаа тогтоох боломжийг нээж өгөв.

Монгол Улс тусгаар тогтнолоо зарлан тунхагласны дараа дээрх гэрээ бичиг Монгол Улсын статусыг олон улсын хэмжээнд тодорхойлон тогтоох албан ёсны анхны олон улсын эрхзүйн баримт бичиг болов. ²

Монгол-Оросын Найрамдлын гэрээнд гарын үсэг зурсны дараа тун удалгүй Финландын эрдэмтэн, дипломатч Густав Ж.Рамстедт (Gustaf John Ramstedt, 1873-1950) Монголын удирдагчидтай уулзах үеэрээ санал тавихдаа Монгол Улс хоёр хөршөөс гадна олон улсын хэмжээнд өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэхийн тулд их гүрнүүдэд тусгайлан хандах учиртайг онцолсон баримт юм. Тийнхүү 1912 оны 11 дүгээр сарын 18-нд Монгол Улсын ГХЯ-наас ноот бичиг үйлдэн «Их Фа (Франц), Ин (Англи), Дэ (Герман), Мэй (АНУ), Билиш (Бельги), Бин (Япон), Дан Ма (Дани), Хэ Лан (Голланд), Ау (Австри) зэрэг есөн гүрний ГХЯ-нд Харбинд суугаа тэдгээр орны консулуудад Хөлөнбуйрын сайдаар дамжуулан өгчээ. (1) Голланд, Дани, Австрийн консулууд Харбин хотноо байгаагүй тул 1912 оны сүүлчээр Гадаад Хэргийн сайд Чин ван М.Ханддорж Санкт-Петербургт айлчилахдаа хүргүүлжээ. Ноот бичигт: «...дурьдсан улсын Засгийн газруудтай дипломат төлөөлөгчид солилцож, ... харилцан гэрээ байгуулж, худалдаа нэвтрүүлж, улсын найрамдлыг зузаатгамуу» (2) гэсэн саналыг дэвшүүлсэн байна. Энэ ноот Монгол Улсаас Өрнөдийн их гүрнүүдэд хандсан албан ёсны анхны баримт бичиг байв.

Нэг сарын дараа Богд хаанаас хичээнгүйлэн Их Фа, Ин, Дэ, Билиш, Хэлан зэрэг таван улсын эзэн хааны амгаланг эрж, үүрд сайнаар найрамдахыг хүссэн албан бичгийг ч Бээжин дэх ЭСЯ-дад тухайлан илгээжээ. Үүнийгээ 1913 оны өвлийн эхэн сарын хууч дор Ерөнхий сайд, Сайн ноён хан Т.Намнансүрэн Санкт-Петербургт айлчилахдаа болон 1914 онд ГЯЯ-наас Бээжин дэх АНУ, Франц, Англи, Германы ЭСЯ-дад дипломат ноот бичиг дахин илгээж Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх шинэ оролдлогыг үргэлжлүүлэн хийж байжээ.

Монгол Улсын Засгийн газар гуравдагч улс оронтой харилцаа тогтоож, тусламж авах талаар Япон улсад ихээхэн найдвар тавьж байв. Тиймээс Монгол Улсын хаан, Засгийн газраас Японы эзэн хаанд хандсан дипломат ажиллагаа онцгой байр эзэлнэ.

2 О.Батсайхан. Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монголын 1915 оны Хиагтын гэрээ. УБ., 2002, 116 дахь тал

Ерөнхий сайд Сайн ноён хан Т.Намнансүрэн тэргүүтэй төлөөлөгчид 1913 оны 11 дүгээр сард Санкт-Петербургт айлчлах дор Богд хааны нэрийн өмнөөс Япон улсын эзэн хаанд хандсан “Төрийн бичиг”-ийг авч явсан билээ. «Төрийн бичиг»-ийн гол агуулга нь Япон улсад урьд тавьсан хүсэлтээ дурьдан сануулаад, шинээр буй болсон нөхцөлд Хятадын Засгийн газарт нөлөөлөн Өвөр Монголд хятад цэрэг оруулахыг зогсоолгох, Ар, Өвөр Монгол нэгдэн Нэгдсэн Монгол Улс байгуулахад туслуулах, Япон улсаас Бүрэн эрхт элчин Монгол Улсад томилон илгээж, дээрх «манай улс байгуулах ажилд» туслалцуулах явдал байжээ.

Хиагтын гурван улсын гэрээ Монгол Улсын дипломатын түүхэнд онцгой байрыг эзэлдэг. Бүтэн 8 сар гаруй хугацаанд 60 гаруй удаа хуралдан удтал маргалдан тэмцэлдсэний эцэст Монголын тусгаар тогтнол хязгаарлагдсан ч гурван талын хэлэлцээрт оролцсоноор Монгол Улс олон улсын харилцааны эрхзүйн субъект байх чадвар бүхий этгээд болохоо харуулсан юм.

Ерөнхий сайд Сайн ноён хан Т.Намнансүрэн 1913 оны 9 дүгээр сард нийслэл Өргөөд ирсэн Кодама Камэкачи хэмээх япон иргэнтэй ГХЯ-ны дэд сайд Б.Цэрэндоржоор хэлмэрчлүүлэн уулзахдаа Оросоор зуучлуулан Хятад-Орос-Монголын хооронд гурван улсын гэрээ байгуулах бодолтой байгаагаа хэлж, үүнд Япон нэгдэн орж дөрвөн талын болгох боломж бий эсэх, үүнийг Японы Засгийн газарт цахилгаан мэдээ явуулж уламжилж өгөхийг хүсч байжээ.³ Монгол Улсын Засгийн газрын тэргүүн Монголын хувь заяаг Орос, Хятад үгсэн хэлэлцэж байсан тэр хүнд үед Гурван талын хэлэлцээрт Японыг татан оруулж дөрвөн талын болгох хувилбарыг хүртэл бодож байсан нь нэн чухал байр суурийн илрэл юм.

1912 онд Харбин дахь Япон улсын консулаар дамжуулан Монгол улс тусгаар тогтносныг мэдэгдэж, гэрээ байгуулах, найрамдал, худалдааны харилцаа тогтоох хүсэлт тавьж, 1913 оны эхээр Дотоод яамны тэргүүн сайд Сүжигт чин ван да лам Цэрэнчимэд, Бүгд ерөнхийлөн захирах яамны дэд сайд Бинт чин ван Гончигсүрэн нар Япон улсыг зорьж, Богд хааны захидал бичгийг Японы Цог жавхланта

3 Ц.Батбаяр. Кодама, Мицуй пүүс, Хүрээнд байсан Япончууд (1911-1921 он) УБ., 1993, 25 дахь тал

эзэн хаанд биеэр хүргэх, утга нь Монголын улс төрийн нэгдлийг хангахад туслах, Өвөр Монголыг эвээлдээ авах, тусгаар тогтнолоо зөвшөөрүүлэх, худалдааны харилцаа тогтоох агуулгатай байв.⁴

1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын нэг үе улиран улсад туслагч гүн, Чин зүтгэлт харчин Баянтөмөрийн Хайсан Хаант Оросоос өөр улс Монголыг үл хүлээн зөвшөөрөх аваас Хаагын (the Hague) олон улсын бага хуралд биеэр очиж, их гүрнүүдээр дэмжүүлэхийг хүсч байжээ.⁵

Дурдсан үед Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын Засгийн газрын (King and His Holliness VIII Bogdo Jabtsundamba khutukhtu Government) дипломатын талаар олсон амжилтын чухаг хэсэг нь Түвдтэй байгуулсан 1913 оны есөн зүйлт Гэрээ бичиг мөн. (3) Их гүрнүүд олон улсын харилцааны хэрэг явдлыг ил, далд элдэв аргаар бүхэлд нь шийдвэрлэж байсан тухайн үед бага буурай хоёр улс, ард түмэн бие биеийнхээ тусгаар тогтсоныг de jure харилцан хүлээн зөвшөөрч, найрамдлын барилдлага, харилцан туслалцах холбоотны гэрээ байгуулж байсан нь бараг ховор юм. Үүгээрээ сайхь гэрээ нь олон улсын харилцаа, дипломатын түүхэнд шинэхэн зүйл болсон гэж үзвээс зохилтой бөгөөд Олноо өргөгдсөн (All elevated) Богд хаант Улсаас түүх, соёл, шашин шүтлэг нэгт «гуравдагч» улстай байгуулсан анхны эрхзүйн баримт бичиг байв. Тухайн үед Түвдийн Засгийн хэрэг эрхлэх газарт гэрээг «Түвд, Монголын найрамдлын Хүндэт гэрээ» гэж тэмдэглэсэн байна.⁶

Гэвч ийм гэрээ байгуулагдсан эсэх хийгээд энэ гэрээ байгаа эсэх, Монгол, Түвд нь олон улсын эрхзүйн субъект мөн эсэх, улмаар Монгол, Түвд нь гэрээ байгуулах эрхзүйн чадамжтай эсэх, гэрээний агуулгын хүчин төгөлдөр байдал, гэрээнд гарын үсэг зурсан төлөөлөгчдийн бүрэн эрх, гэрээ нь улс төрийн ач холбогдолтой эсэх, их гүрнүүдийн байр суурь, чиг хандлага, тухай үеийн Монгол, Түвдийн геополитикийн орчны хувьсал, өөрчлөлт, дотоод улс төрийн нөхцөл байдал, дурдсан гэрээ 1922 онд Ардын Засгийн газраас Түвдийн Засгийн газарт илгээсэн

4 Мөн тэнд

5 ГХТА. Ф-53

6 Д.Уламбаяр. «Олноо өргөгдсөн Хаант Монгол улсын дипломат ажиллагаанд Монгол-Түвдийн 1913 оны гэрээний эзлэх байр суурь»-“Монгол-Түвдийн 1913 оны гэрээ-100 жил” Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2012, 61-66 дахь тал

ноот бичигтэй хэрхэн холбогдсон, 1925 онд Монгол Улс Түвдтэй ЭСЯ-ны хэмжээнд дипломат харилцаа тогтоох оролдлого зэрэг эргэлзээтэй, бүрхэг олон асуудал байсаар иржээ.

Шинэ тутам байгуулагдсан ГХЯ-нд төрийн хэрэгт үнэнч, тухайн үедээ мэдлэг боловсрол сайтай, хятад, манж, түвд зэрэг хэл бичиг эзэмшсэн, мөн япон хэл бичиг гадарладаг хүмүүсээс сонгон авч ажиллуулж байсан байна. Харин орос хэлтгэй хүн ховор байсныг харгалзан 1912 онд яамны дэргэд Хүрээн дэх Оросын консулын тусламжтайгаар монгол, орос хэл бичгийн сургууль байгуулан ажиллуулжээ. Түүнчлэн Монгол Улс дэлхийн зах зээлийн хүрээлэлд улам бүр татагдан орж, Өрнөд Европ, Америкийн капитал монгол газар цутган орж ирэх болсон хийгээд нөгөө талд Богд хаант Монгол Улсаас гадаад дахинтай өргөн дэлгэр харилцах шаардлага нь боловсон сургуулийг үүсгэн байгуулж, монгол болон гадаад хэл бичигтэй үндэсний сэхээтнүүдийг бэлтгэхтэй холбогдож байв. Гадаад яамнаа соёлын асуудал эрхэлсэн туслах түшмэл бээр уригдан ирсэн Ж. Цэвээн (Жамсранов) 1912 оны эхээр «...ард албатын мунхаг харанхуйг эрдмийн зул бадруулж гийгүүлсүгэй» хэмээн хүсэл зоригоо илтгэн ГХЯ-ны тэргүүн сайд чин ван Ханддоржид өргөсөн бичигтээ: «Гадаад олон хүчирхэг улсын хамаг чадал нь гагцхүү элдэв ухааны эрдэм дор нэвтрэлцэн дээд, доод эрдэм ялгалгүй цөм бага наснаас эхлэн хирээр адаг, дунд, их гурван сургууль ... дор явж зүйл бүрийн ухааныг өөр өөрийн төрөлх хэл дээр судалснаар энэ мэт хүчирхэг болжээ... Бүгдээр нийт тусгай олон тооны эрдэм дор нэвтрэлцэхийг ямагт шамдан хичээвээс зохимой. Үлгэрийг гадаад улсаас авч Монгол байдал дор тааруулж тогтоовоос зохимой» (4) гэжээ.

1915 оны 8 дугаар сард боловсрогдож гарсан, орос-монгол хэл бичгийн сургуулийн дүрмийн хоёрдугаар бүлгийн долдугаар зүйлийн хоёрт, заавал үзэх хичээлийн тоонд орос, хятад хэл бичгээс гадна «...Ин (Англи), Фа (Франц) зэрэг улсын бичиг үсэг, үг хэлийг ... гол болговоос зохистой» (5) гэжээ. 1914 оны 12 дугаар сард ГХЯ Хятад газар болон Оросын Эрхүү хотод багшилж байсан Англи улсын иргэн Уйдинг багшийг урин ирүүлж ажиллуулсан бөгөөд тэрбээр багшлах үйлсэд үнэнхүү зүтгэл гаргасны учир Богд гэгээний Засгийн газраас тусгайлан шагнаж байжээ. 1914 оны 5 дугаар сард тус сургуулийг ГХЯ-

нд эрхлүүлэх тухай тушаан шийтгэх бичиг гарч захирлаар нь Гадаад хэргийн дэд сайд, нягт билэгт, гүн, да лам Равдан хавсран ажиллахаар болсон байна.(6)

1915 оны Хиагтын гурван улсын Гэрээгээр Монгол Улсын тусгаар тогтнолыг хязгаарлаж, Хятадын хэмжээт эзэрхэл (suzerainete), Оросын хамгаалал (protectorate) дор автономит улс болж, тус орны дотоод, гадаад улс төрийн амьдрал ээдрээ төвөгтэй болсон, Европт дэлхийн I дайн эхэлсэн нь Хаан Оросын Алс Дорнод дахь нөлөө ялангуяа Монголд мэдэгдэхүйц буурсан нь Хятадын тийм нөлөө Монголд тэр хэмжээгээр өсөхөд хүргэж байв.

Автономитыг цуцалсны дараа түүхэн эгзэгтэй нөхцөлд Жалханз хутагт Дамдинбазар, Дилав хутагт Жамсранжав нарын зэрэг нөлөө бүхий ноёд Америкийг түшиглэх санаа гаргаж энэ нь Богд хааны дэмжлэг хүлээж байсан бөгөөд үүний мөрөөр 1919 оны өвлийн эхэн сард Бээжинд АНУ-ын Хэргийг түр хамаарагч Чарльз Д.Теннитэй,⁷ 1920 оны хаврын дунд сард Өргөөд Тяньжин дахь АНУ-ын консул Чарльз Х.Эберхардт лугаа нууц уулзалтууд явагдаж байв. Уулзалтын гол агуулга нь АНУ-ын Засгийн газрыг Гадаад Монголын автономит эрхийг сэргээх тухайд Хятадын Засгийн газарт сануулга өгөх, Америк улс өөрийн шууд хамгаалалдаа авах, Өргөөнд Америкийн Консулын газрыг хурдан нээвэл улс төр, худалдааны харилцаа ихэд хөгжих тухай асуудалд төвлөрч байжээ. Америк консул мөн Хүрээнд “Mongolian Trading Company”-н төлөөлөгч А.М.Гуптилл, “Andersen, Meyer & Co.”-ын төлөөлөгч Ф.А.Ларсон нартай уулзжээ. Тэд Өргөөд Америкийн Консулын газрыг нээхийн зайлшгүй нь нэгд. Улс төрийн нөхцөл байдал, хоёрт. Гадаадынхны эрх ашгийг хамгаалах, гуравт. Өсөн нэмэгдэж буй худалдааны үйл ажиллагаа эдгээр болно гэж онцлон дурдаж байжээ.⁸

1920 оны зун Жалханз хутугт тэргүүтэй төлөөлөгчид хоёрдахь удаагаа Бээжин явахад Дилав хутугт бүрэлдэхүүнд нь оржээ. Дилав хутугт энэ аяллын тухай дэлгэрэнгүй өгүүлэхдээ төлөөгчдийн чухал зорилго нь Монголын автономийг сэргээхэд Америкийн дэмжлэг

⁷ Diluv Khutagt, *Memoirs and Autobiography of Mongol Buddhist Reincarnation in Religion and Revolution* by Owen Lattimore and Fujiko Isono. Wiesbaden.: 1982, pp. 167-169

⁸ Alicia Campi...*The Impact of China and Russia on United States-Mongolian Political Relations in the Twentieth Century*. The Edwin Mellen Press. N.Y.: 2009, pp. 65-78

олох явдал байсан гэжээ. Жалханз хутугт Бээжинд АНУ-ын элчин сайд Чарльз Р.Крэне, Дилав хутугт цэргийн атташе хошууч Уоллес С.Филльонтой тус тус нууц уулзаж ярилцан санал солилцжээ. Ф.Ларсон аль аль уулзалтад хэлмэрчээр оролцжээ. Америкийн дипломатууд Монголын саналыг Засгийн газартаа уламжлахыг хариуцлагатайгаар амлаж байжээ.⁹

Сайхь уулзалтууд Монгол-Америкийн харилцааны түүхэнд болсон хамгийн анхны албан ёсны яриа хэлэлцээнүүд байжээ.

Цогт гүн Бадамжав зэрэг зарим ноёд Америк улс хол оршдог, Японоос тусламж хүсвэл хялбар бөгөөд хурдан бүтнэ гэж байсан боловч Япончууд Солонгосыг хэрхэн эрхшээлдээ оруулсныг монголчууд нэгэнт мэдсэн байв. Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсын эхний жилүүдэд Японы улс төрийн дэмжлэгт түшиглэх, түүнд ихээхэн найдвар тавьж байсан бол Автономитийн сүүлчийн улирлаас ихээхэн болгоомжлох болов.¹⁰

Олноо өргөгдсөний 11 дүгээр оны хаврын тэргүүн сарын 15 буюу 1921 оны 2 дугаар сарын 21-нд Барон Унгерны дэмжлэгтэйгээр Монголын Автономыг дахин сэргээхэд Богд гэгээнийг ширээнд нь дахин залж, Ерөнхий сайд бөгөөд Дотоод хэргийн тэргүүн сайдад Жалханз хутагт Дамдинбазар, Гадаад хэргийн тэргүүн сайдад шанзодба Дашжав болон бусад сайд нарыг тохоон томилжээ. Богд гэгээний Засгийн газар сэргээн байгуулагдсан Автономит Монголын Засгийн газрыг олон улсаар хүлээн зөвшөөрүүлэх талаар мөн адил чармайж, Дундад улсын ерөнхийлөгч, Зөвлөлт Оросын Гадаад хэргийн ардын комиссар, Францын Засгийн газарт ноот бичиг илгээсэн ажээ. Уг ноот бичигт Гурван улсын хэлэлцээрийн дагуу Гадаад Монголын Автономитыг сэргээн байгуулах хэрэгт Унгерн үлэмж гавьяа байгуулсан гэж үнэлэхийн сацуу тэдгээр оросуудын үзэл санаа Зөвлөлт Засгийнхантай зөрөөтэй байгаа боловч Монголд энх амгалан байдал бий болгоход ихээхэн зүйл хийж дуусгаад баруун зүг одож байгаа учир хоёр орны хооронд найрамдал, худалдааны найрсаг харилцаа тогтоож элч төлөөлөгчдөө солилцоход саад болохгүй гэжээ.

9 Д.Уламбаяр. Монгол Улс, Алс Дорнодахин: Олон улсын харилцаа, геополитик, дипломат ажиллагаа. XX зууны эхнээс XXI зууны эхэн. Тэргүүн боть. УБ., 2013, 235 дахь тал

10 Д.Уламбаяр. 237 дахь тал

Бичгийн хариуд РСФСР, Дундад улс хоёр эсэргүүцэн няцааж, харин Франц талархсан байна. (7)

Эл үйл явдлын талаар Бээжин дэх Японы ЭСЯ, Хаалган хотоос “Тоа добункай” байгууллагын төлөөлөгч Кониши Шигэрү Токиод мэдээллэхдээ Гадаад Монголын «тусгаар тогтнол» дахин сэргэсэн хэмээсэн нь сонирхолтой юм.

Октябрийн хувьсгалаар Большевикууд Засгийн эрхэнд гарч Зөвлөлт Орос Улс байгуулагдсанаар 1915 оны Хиагтын Гурван улсын гэрээнд оролцогч Хаант Орос олон улсын эрхзүйн субъект байх чадваргүй болсон билээ. Тиймээс ч Зөвлөлт Засгийн газар Барон Унгерны тусламжтайгаар дахин сэргэсэн Автономит Монголын Засгийн газрын талаар эсрэг байр суурьтай байсан нь ойлгомжтой юм.

Харин 1921 оны 3 дугаар сард Хиагтад байгуулагдсан Ардын Түр Засгийн газарт онцгой ач холбогдол өгч байв.

2. 1920-иод оны Ардын эрхт Монгол Улс, Өрнөдийн орнуудын ад хос харилцаа

Монгол Улсын олон улсын эрхзүйн статус, түүнийг хүлээн зөвшөөрсөн түүхэн үйл явцыг шинэлэг байдлаар судлан, үнэнийг тодруулж, үнэлэлт дүгнэлт өгөх шаардлага эдүгээ зүй ёсоор урган гарч, тийм учраас ч дурдсан чиглэлд судлаачид анхаарлаа хандуулж буй нь ч бүрнээ зүй ёсны хэрэг юм.

Улс буюу Засгийн газрын хооронд бие биеэ албан ёсоор харилцан хүлээн зөвшөөрөөгүй, үл зөвшөөрөх бусад учир шалтгаантай боловч тодорхой асуудлуудыг шийдвэрлэхийн тулд түр зуур албан ёсны харилцаанд орох тохиолдол олон улсын харилцааны түүхэнд түгээмэл байсан бөгөөд эдүгээ ч байгаа юм. Үүнийг дипломатын эрхзүйд ад хос хүлээн зөвшөөрөх гэдэг ажгуу.

1920-иод онд Ардын эрхт Монгол Улс, Өрнөдийн томоохон гүрэн АНУ, Герман улсын [1918-1933 оны хоорондох Герман улсын албан ёсны нэр нь Ваймерын Бүгд Найрамдах Улс Д.У] хооронд олон улсын эрхзүйн ад хос харилцаа тогтсон гэж дүгнэж болохоор байна.

Тийнхүү 1921 оны 7 дугаар сард Монгол оронд үндэсний ардчилсан хувьсгал ялсан нь Өрнөдийн гүрнүүдтэй харилцаагаа шинээр үүсгэн хөгжүүлэх шинэ боломжийг буй болгов.

1920-иод оныг тус орны улс төр, эдийн засаг, оюуны амьдралд эргэлтийн шинжтэй ч гэж хэлж болохуйц, ингэхлээрээ нарийн түвэгтэй, үүгээрээ Монгол Улсын шинэхэн түүхийн нэн сонирхолтой үе гэж хэлж болохоор юм. Учир нь урьд өмнө шийдвэрлэж байгаагүй олон чухал асуудлууд энэ үед цоо шинээр дэвшигдэн гарч иржээ. Улс төрийн зүтгэлтнүүд, олон түмэн тэдгээр үзэгдэл, үйл явцыг өөр өөрийнхөөрөө үнэлж цэгнэж, янз бүрээр хандаж байв. Шинэ цагийн мэдлэг боловсрол, туршлагатай боловсон хүчин ч ихээхэн дутагдаж байдлыг улам түвэгтэй болгож байсан нь ойлгомжтой. Ийм түүхэн нөхцөлд улс орны тусгаар тогтнолыг хоёр хөршөөс гадна «гуравдагч хөрш»-өөр хүлээн зөвшөөрүүлэх, төвийг сахих дор нийгэм журам тийш хөгжүүлэх янз бүрийн хувилбаруудыг улс төрийн зүтгэлтнүүд шаргуй эрэн хайж эхэлжээ. Үүнд АЗГ-ын Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны тэргүүн сайд Д.Бодоо зүй ёсоор орно. Тэрбээр ардын төрийн хэлбэрийг улс орны байдалтай харьцуулан шинжлээд эв хамт төр, цэвэр парламентын ёс, хэмжээгүй эрхт ёсны алин нь ч Монголд таарахгүй, харин хэмжээт цаазат хаантай, үндсэн хуулийн парламентын хэлбэр буюу Английн төрийн байгууламжийг үлгэр болгон өөрийн улсын өвөрмөц байдал дор зохицуулан хэрэглэж болох юм гэсэн санаа дэвшүүлж байв.¹¹ Сангийн сайд С.Данзан бээр Монгол орон нийгэм журамд шилжихийн өмнө хөрөнгөт ёсны замыг удаан, түргэн ямар нэг байдлаар туулах ёстой, боловсон улсууд бүгд энэ замыг дамжиж ирсэн, Монгол орны хоцрогдлыг даван туулах гагц зам бол капиталын ёсонд орж «боловсрох» явдал гэдэгт бат итгэж байсан ажээ. Тэрбээр энэ талаарх байр сууриа 1922 оны хавар МАН-ын ТХ-нд өргөсөн саналын бичигтээ тодорхой илэрхийлсэн байдаг.¹² Профессор Ж.Цэвээн бээр монгол угсаатны бүрэлдэхүүнтэйгээр Улаанбаатар хотоор төвлөрсөн Төв Азийн федераци байгуулах, Хятадын сюзернитет ч биш, ЗСЕНХУ-ын протекторат ч биш, харин ЗСБНХУ, Хятад зэрэг улсаас баталсан бөгөөд бусад олон улсаас хүлээн зөвшөөрсөн, ер нь Швейцари лугаа төвийг сахисан улс байх ёстой, чухамхүү ийм болж чадах аваас Монгол хэмээх хоцрогдсон нэгэн улс орон амар төвшнөөр соёл боловсролын хөгжлөө хангаж чадна гэж үзэж байв.¹³

11 Лха. Бат-Очир. Д.Бодоо сайд: Үзэл ба үйлс. УБ., 1991, 22 дахь тал

12 Ө.Бадрах. Намаас барууны бөөрөнхийчүүд лугаа тэмцсэн амжилттай их тэмцлийн туршлага. УБ., 1930, 47- 52 дахь тал. Орос орчуулга, НТА.Ф.1.Т.32.ХН.3

13 Заявления Ц.Жамцарано в ЦК МНРП. Ф.1.Т.4.ХН.99

1921 оны үндэсний ардчилсан хувьсгал ялсны дараа 9 дүгээр сарын 12-нд Ерөнхий сайд бөгөөд Гадаад Хэргийн тэргүүн сайд Д.Бодоо Чуулалт-Хаалган хотноо Гадаад Монголыг тусгайлан хариуцаж суусан Америкийн анхны суурин консул Самуэл Сокобиныг анх хүлээн авч уулзан хэлэлцэхдээ Монголын үндэсний ардчилсан хувьсгал ялсны дүнд Ардын эрхт, хэмжээт цаазат засаг тогтсон үнэнхүү учир байдал хийгээд түүний гадаад, дотоод бодлогын тухай тайлбарлахын хамт өөрийн нэрийн өмнөөс АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргад (тухайн үед Charles Evans Hughes ажиллаж байжээ) хандсан илгээх ноотыг ноён консулд гардуулжээ. Тэрхүү ноотод: «...Америк улсын Гадаад хэргийн яамны эрхэм сайд танаа...Одоо гагцхүү тусгайлан илтгэх нь манай Богд хаан ба Засгийн газар хийгээд олны санал улсын Засгийн газраас манай Монголын Ардын Засгийн газартай эртхэнээ гэрээ байгуулан, элчин сайд суулгаж, худалдаа, арилжааг улмаар бадруулан хоёр этгээдийн ашиг тусыг хөгжүүлэхийг хүсч байгаа тул эрхэм сайд Та толилж даруйхнаа баяртай хариу хүртээх ажаамуу» гэжээ. Дурьдсан ноот Нью-Йоркт хэвлэгддэг «The Nation» сэтгүүлийн 1921 оны 11 дүгээр сарын 13-ны дугаарт тайлбар, бүрэн эхээрээ «Mongolia Speaks to the World. Chairman of the Council of Ministers and Minister for Foreign Affairs of Mongolian People's Government Mr. Bodo» нэртэйгээр нийтлэгдсэн байна. (8) Хуучин түүх бичлэгт энэхүү ноот бичгийг АНУ руу яаж илгээсэн нь тун бүрхэг байсан билээ.

Америк консул С.Сокобин Ерөнхий сайдтай уулзахдаа Монгол Улс тусгаар тогтносоо албан ёсоор нотолж, гадаад олон улсуудад ялангуяа Дундад иргэн улс болон Өрнөдийн гүрнүүдэд тунхаглан зарлах нь чухал болохыг зөвлөсөн баримт юм. Үнэхээр ч хоёр хоногийн дараа буюу 9 дүгээр сарын 14-нд өөрийн нэр дээр «Монгол Улсыг тусгаар тогтносон тухай гадаад олон улсуудад тунхагласан бичиг» гаргасан нь хоёр хөршөөс гадна Дундад болон Өрнөдийн орнуудад хандсан хэрэг байв. Тийнхүү «...Монголын хүн иргэнийг тус тусдаа энх түвшний улиралд хандуулахыг гүнээ эрмэлзэн бүхий дээр, бас ч гадаад олон улстай гэрээ байгуулан худалдаа арилжааг нэгэн адилаар нэвтрүүлэхийг эрмэлзэн байгаа явдлыг хамтад илэрхийлэн гаргав» (9) хэмээн дэлхий дахинд зарлажээ.

Америк консул С.Сокобин Монголын талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж, нийслэл Өргөөд 5 удаа ирж байжээ.¹⁴

Удалгүй Монголд болсон хэрэг явдлыг газар дээр нь ажиглаж, цаашлаад харилцаа, холбоо тогтоох зорилгоор Германы Бээжин дэх ЭСЯ-ны худалдааны атташе, Москва дахь Германы ЭСЯ-ны төлөөлөгч, Дорнод Европыг судлах Германы нийгэмлэгийн нарийн бичгийн дарга нар Хүрээнд ирсэн тухай «Власть труда» сонины 1922 оны 8 дугаар сарын 19-ний дугаарт тэмдэглэсэн байна.¹⁵

Дээрхийг тодруулахад 1922 оны 8 дугаар сарын 19-нд Германы Бээжин дэх ЭСЯ-ны худалдааны атташе, консул Х. Гипперих (Hermann Gipperich 1859-1954),¹⁶ Москва дахь Германы ЭСЯ-ны зөвлөх, доктор Р.Асмис (Dr. Rudolf Asmis 1872-1953), Дорнод Европыг судлах Германы нийгэмлэгийг (Deutsche Gesellschaft fuer Osteuropakunde-DGO) үндэслэгч, түүхч эрдэмтэн доктор О.Хетш (Hoetzsch Otto 1876-1946) нар нийслэл Хүрээнд ажлын айлчлал хийсэн бөгөөд тэд Өргөөд 1922 оны 7 дугаар сарын эхнээс 8 дугаар сарын эхэн хүртэл сар орчим хугацаанд ажилласан байна.¹⁷ Профессор О.Хетш «Osteuropa» сэтгүүлийг үндэслэгч бөгөөд Райхстагийн гишүүн улс төрч, 1922 онд ЗХУ, Монголд судалгааны томилолтоор ажиллажээ.

Тэдний айлчлал 1919 оны Версалийн гэрээний дараа 1921 оны 5 дугаар сарын 20-нд Бээжинд Хятад-Германы хооронд энхийн хэлэлцээр¹⁸ байгуулагдаж, 9 дүгээр сард Хятадад шинээр томилогдож ирсэн элчин сайд Адольф Боуе (Adolf Boye), консул Вилгельм Вагнер

14 Д.Уламбаяр. «Гадаад Монголыг хариуцсан АНУ-ын анхны суурин консул Самуэл Сокобин»-«Pax Mongolica» сэтгүүд, ШУА, ОУХХ, Vol.3 2017 №1 (6) 116-146 дахь тал

15 Газ: «Власть труда». 19 август 1922, УТТА. Ф.382. Т.3. ХН.51

16 1921 оны 5 дугаар сарын 20-нд Бээжинд Хятад, Германы (Weimar Republic) харилцааг сэргээх тухай энхтайвны хэлэлцээрт Хятадын БНУ-ын ГЯЯ-ны сайд W.W Yen, Германы Засгийн газрыг төлөөлж Ерөнхий консул von Borch нар гарын үсэг зуржээ. Хятадын БНУ дэлхийн I дайны төгсгөлд Германы эзэмшилд байсан Шаньдун мужид Хятадын бүрэн эрхийг хэрэгжүүлэх зорилго тавьж, 1917 оны 8 дугаар сарын 14-нд Антантын (Entente Powers) талд нэгдэж, Германы райхт дайн зарлажээ. Гэвч 1919 оны 6 дугаар сард зохион байгуулагдсан Версалийн гэрээгээр Шаньдун мужийг Японд шилжүүлсэнд Хятад эсэргүүцлээ илэрхийлж гэрээнд гарын үсэг зураагүй юм. Тиймээс Хятадын ерөнхийлөгч 1919 оны 9 дүгээр сарын 15-нд зарлиг гаргаж, Германтай салангид энхийн хэлэлцээг эхлүүлэхээр шийдвэрлэж, ийнхүү дээрх гэрээний дараа Германы ЭСЯ Бээжинд сэргээн нээгджээ.

17 Д.Уламбаяр. Монгол Улс, Алс Дорно дахин: Олон улсын харилцаа, геополитик, дипломат ажиллагаа. XX зууны эхнээс XXI зууны эхэн. Тэргүүн боть. УБ., 2013, 238-239 дэх тал

18 1917 оны 8 дугаар сарын 14-нд Хятад нь Шаньдун мужийг өөрийн бүрэн мэдэлд шилжүүлж авах зорилгоор Германд дайн зарлаж, Холбоотны талд орсон ч Версалийн гэрээгээр Шаньдун нь Хятадад биш, Японд шилжсэний улмаас Хятадын төлөөлөгчид тус гэрээнд гарын үсэг зураагүй юм. 1921 оны 5 дугаар сарын 20-ны Бээжингийн гэрээг 1922 оны 5 дугаар сарын 14-нд Лиги Нацид бүртгүүлсэн байна.

(Wilhelm Wagner), худалдааны атташе Х. Гипперих (J.A.Hermann Gipperich), 1922 оны 4 дүгээр сарын 16-нд Рапаллод (Treaty of Rapallo) Зөвлөлт-Германы хооронд бүрэн хэмжээнд дипломат харилцаа тогтоох тухай гэрээнд гарын үсэг зурж (урд нь 1921 оны 5 дугаар сард Герман нь Зөвлөлт Засгийн газрыг хүлээн зөвшөөрсөн юм), Москвад шинэ элчин сайд Ульрих граф фон Брокдорфф-Ранцау (Ulrich Graf von Brockdorff-Rantzau), элчин зөвлөх, доктор Р.Асмис (Dr. Rudolf Asmis), нарийн бичгийн дарга Г.Хилгер (Gustav Hilger) нар ажилдаа орсны дараа болсноороо онцлог байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Монголын Засгийн газар тэдний айлчлалд ихээхэн ач холбогдол өгч, худалдааны харилцаа тогтоох, тэр ч байтугай худалдааны хэлэлцээр байгуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлж байжээ. Зочид Ерөнхий сайд жалханз хутугт С.Дамдинбазар, Ерөнхий сайдын жинхэнэ орлогч бөгөөд Сангийн сайд С.Данзан, ГЯЯ-ны сайд Б.Цэрэндорж, Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжин Д. Сүхбаатар лугаа уулзалтууд тус тус хийжээ. (10)

ХБНГУ-ын Бундесархивт шинээр олдсон нэгэн чухал эх сурвалжид Германы дипломатчдын Монголд хийсэн айлчлалын үеэр Монгол Улсын Сангийн яамны тэргүүн сайд С.Данзангаас “ Их Герман улсаас Думдад Иргэн улсын нийслэлд суугаа Элчин сайдын яамны худалдааны хэргийн зөвлөгч Гипперих”-д Олноо өргөгдсөний арван хоёрдугаар он 5 сарын 23 буюу 1922 оны 7 дугаар сарын 18-наар өдөрлөсөн 567 тоот албан захидал илгээжээ. (11) Сайхь нугалбар албан бичгийн (үндсэн эх, орос, герман орчуулгын хамт) гол зорилго нь Монгол Улсын Засгийн газар Герман Улсын худалдааны пүүсүүд Монголоос мал болон ангийн гаралтай түүхий эд худалдан авч, Германаас төрөл бүрийн өргөн хэрэглээний бараа авчран худалдаалахад дэмжлэг үзүүлэх төдийгүй цаашид худалдааны харилцаа тогтоох замаар хоёр орны хооронд найрамдалт харилцааг хөгжүүлэх сонирхолтой байгаагаа Бээжин дэх ЭСЯ-аар нь дамжуулан Засгийн газарт нь хүргэх явдал байжээ. Консул Х.Гипперих Бээжинд буцаж очоод албан захидлыг монгол эх, орос, герман орчуулгын хамт Берлинд илгээжээ. Тухайн үед Ваймерийн БНУ-ын Рейхсканцлер бөгөөд Гадаад хэргийн сайдаар Карл Йозеф Вирт (Karl Josef Wirth, 1879-1956) ажиллаж байжээ.¹⁹

19 Карл Йозеф Вирт ЗХУ-тай харилцаагаа хэвийн болгох байр суурь баримталж, улмаар 1922 оны 4

Томилолтынхоо дундуур германы дипломатч Гипперих Өргөөгөөс ГЯЯ-ндаа илгээсэн мэдээндээ: «Ерөнхий сайд Жалхунз хутагт Дамдинбазар намайг буцахаас өмнө дахин хүлээн авч уулзаж, Монголын Засгийн газрын өмнөөс Герман, Монгол хоёр улсын хооронд худалдааны хэлэлцээр хийх эрмэлзэлтэй байгаагаа дахин илэрхийлэв» гэжээ. Мөн эдийн засгийн тухайд Монголд «...Германы нөлөөг бэхжүүлэхийг сайншаах төлөвтэй. Ингэснээр Оросын дангаар ноёрхох явдлыг багасгах боломж буй. Оросууд Монголд гүйцэтгэж буй үүрэг, нөлөөгөө Германчуудтай хуваахад бэлэн байгаа эсэхийг Москвад нарийн судлах шаардлагатай байна» (12) гээд хоёр орны худалдааны хэлэлцээр улс төрийн нөхцөл байдлаас болж хойшилж байгааг дурджээ. Үүнээс хэд хоногийн дараа 8 дугаар сарын 5-ны өдөр Ерөнхий сайд, Гадаад болон Цэргийн яамны сайд нарт бараалхсан Германы дипломатч доктор Асмис Монголын талын дээрх хүсэлтийг дахин нотолж, өөрийнхөө тэмдэглэлд: «Монголын нийгмийн бүх давхаргын нийтлэг нэгэн хандлага бол Герман улсад найрсаг элэгсэг дотно хандаж байгаа явдал юм. Бас иймэрхүү байдалтай хүлээн авч, уулзах байх гэж горьдсон гадаадын зарим худалдаачид өөрийгөө Герман хүн хэмээн танилцуулсан тохиолдол ч бий» (13) хэмээжээ. Бүх уулзалт ярианд Монголын Ла гүн хэмээн алдаршсан Франс Август Ларсон хэлмэрчилж байжээ.

1920-иод онд Монголын нам, засгийн удирдах зарим зүтгэлтнүүд нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгааг үл харгалзан өндөр хөгжилтэй Өрнөд Европын зарим оронтой худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох чиглэлийг барьж байсныг 1923 оны 7 дугаар сарын 24-нд тусгай комиссоос боловсруулан нийтэлсэн 18 зүйл бүхий “Эдийн Засгийн үндсэн бодлого” хэмээх Засгийн газрын бодлогын шинж чанартай баримт бичиг басхүү тодорхой илтгэнэ.

Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах ажил 1922 онд эхэлж, Засгийн газрын шийдвэрээр ГЯЯ-ны сайд Б.Цэрэндорж, Дотоод яамны дэд сайд бөгөөд Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бигийн дарга Ж.Цэвээн, Судар бичгийн хүрээлэнгийн дарга О.Жамьян нарын бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

дүгээр сард Италийн Раппало хотод Зөвлөлт-Германы хооронд дипломат харилцаа тогтоох тухай гэрээнд гарын үсэг зуржээ. Соёрхосон багламжийг 1923 оны 1 дүгээр сарын 31-нд Берлинд солилцож, мөн оны 9 дүгээр сарын 13-нд Үндэстнүүдийн Холбоонд бүртгүүлсэн байна.

Тэрхүү баримт бичгийн 17 дугаар зүйлд: «Монгол Улсын гадаад харилцааны учир байцаавал Орос, Рибин, Америк, Англи, Герман зэргийн олон их, бага улс дотроос зарим нь хурц эрдэмтэй, зарим нь бүдүүлэг байх мэт чанар дүрс адилгүй учраас зүй нь харилцан худалдаа, ашиг, эрдэм, соёлын тухай гэрээ болзоо тогтоон нэвтрүүлэхэд хүрвэл эрх биш хэдэн давхар эргэцүүлэн хянаж тогтоовол зохино. Герман, Англи, Орос, Америк, Хятад, Рибин хэмээн шилэх сонгоход хүрвэл аль ч талаар Герман, Орос, Америк хэмээх мэтээр дэс дараалан орох буй заа» (14) гэжээ. Энэ баримт бичгийг 1923 оны 7 дугаар сард хуралдсан МАХН-ын II их хурлаас «намын программд нэмэн өргөтгөж баталсан 9 дүгээр зүйлтэй адил сацуугаар улс төрийн ба намын хэрэгт удирдлага болговол зохино» (15) гэжээ.

Дээр дурдсан «Эдийн засгийн үндсэн бодлого» баримт бичгийн 18 дугаар зүйлд монгол залуусыг гадаад оронд сургахдаа гагц Орос улстай хэмээн заасангүй, харин «Урьд эдүгээ аль ч цагт орон газар хаана ч атугай эрдмээр илүү нь эрхбиш түүрүүлдэг учиртайг дэлхий дээрх олон улс ухамсарлан мэдэж, эрдэмд боловсруулахыг Засгийн бодлогын манлай болгожээ» гээд улс орнуудыг боловсролын түвшингээр нь дараалуулахдаа:

«Аль улс	Хэдэн хүнээс	Бичиг үсэг үл мэдэх хэд
Герман	Нэг түмэн	10
Англи	Нэг түмэн	10
Орос	Нэг түмэн	7000
Рибин	Нэг түмэн	100

гэх мэт үлгэртэй бөгөөд эрдэм соёлоор баялаг нь эд хөрөнгө чадал хүчээр аяндаа баялаг ажгуу. Учир тийм тул эдийн засгийг үүрд бат нот арвин зузаан болгоё хэмээвээс ард түмнийг эрхбиш ерийн үсэг бичиг, утга уянга ба тусгай ашиг тус бүхий эрдмүүдэд сургахыг урьдал болговол зохино» (16) гэсэн байна.

1924 онд Монголоос ЗХУ-д суух Бүрэн эрхт элчин төлөөлөгчөөр томилогдсон Баатуудовогт Ажваан Данзанд ГЯЯ-наас өгсөн удирдамжинд ЗХУ-тай харилцаагаа өргөжүүлэхийн зэрэгцээгээр Герман, Итали, Афганистан, Перс, Франц зэрэг гадаад улсад биеэр очиж тэндхийн улс

төрийн байдал, худалдаа, соёлын харилцаа тогтоох боломж, Монголыг хэрхэн үзэж байгаа зэргийг судалж, Монголч эрдэмтэдтэй уулзаж ном зохиолоос нь олж ирүүлэх үүрэг өгч байсан байна. (17) Цаашилбал ЗХУ-аас бусад Франц, Герман, Итали, Афганистан зэрэг гадаад орнуудтай найрсаг харилцаа тогтоон хөгжүүлэх тухай заалт Москва дахь Монголын Бүрэн эрх барих Төлөөлөгчийн газрын 1926 оны дүрэм болон ГЯЯ-ны 1927 оны дүрэмд бас орсон байна. Төлөөлөгчийн газрын үндсэн үүргийг тодорхойлохдоо: «нэгэнт найрамдсан улстай найрамдлыг улам зузаатган бусад гадаад улсаас Москва хотноо суулгасан элчин сайд, төлөөлөгчидтэй учиран танилцаж, тэдний дотроос найрамдваас зохих улстай найрамдлын холбоо байгуулж өөрийн улсад тустай хэрэг бүтээхийг ямагт хичээн оролдож аль аль улстай хэрхэн харилцан нэвтрэлцсэн . . . зэрэг байдал төлөвийг урьд олгосон заавар ёсоор тодорхойлон тухай бүр Засгийн газар ба ГЯЯ-нд уламжлан явуулж гүйцэтгэвээс зохимой» (18) гэжээ.

1925-1929 онд ГЯЯ-ны сайдаар Улсын бага хурал, НТХ-ны тэргүүлэгч гишүүн В. Дорлигжав (1883-1937) ажиллаж энэ чиглэлд ач холбогдол өгч байжээ.

Монгол-Германы 1920-иод оны харилцаанд Москва дахь Монголын ЭСЯ-ны худалдааны төлөөлөгч Цэдэн-Ишийн Дашсампилон тэргүүтэй Засгийн газрын төлөөлөгчдийн 1925-1927 онд Германд хийсэн нижгээд удаагийн ажлын айлчлал чухал байр эзэлнэ. (28) Энэ айлчлал Москва дахь Германы элчин сайд, Ульрихийн гүн Брокдорф фон Ранцау, Монголын Элчин А. Данзантай уулзаж тохиролцсоны дагуу, түүний урилга, идэвхитэй дэмжлэгтэйгээр болсон байна. Гэгээрлийн сайд Эрдэнэ Батхаан, яамны ажилтан Димчигон, туслах Далай тэргүүтэй 40 гаруй сурагч хөвгүүд, охидын айлчлал ч нэгэн адил ажээ. (19)

Архивын өөр нэгэн баримт бол 1926 оны 1 дүгээр сард БНМАУ-ын Ерөнхий сайдын жинхэнэ орлогч, ААЯ-ны сайд А.Амар, Бүх цэргийн зөвлөлийн тэргүүлэгч, Засгийн газрын эрхлэх товчооны гишүүн Н.Жадамбаа зэрэг төлөөлөгчид ЗХУ-д айлчилж, хоёр орны хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тулгамдсан асуудлаар ЗХУ-ын Дипломат албаны тэргүүн Г.В.Чичеринтэй санал солилцож, албан захидал гардуулжээ.

Дурдсан захидалд: «...Үүнд эдийн засгийн тухай хэргийг улс төрийн хэрэгт холбогдуулалгүй хэлэлцэж үл болох тухай явдлыг эрхэм Танаа сануулах юун... Ихээхэн чухал болох зүйл нь худалдаа болно.

Монгол Улсын ба мөн улсын худалдааны газрууд болбоос харьяат улсын түүхий эдийг хаана үлэмжхэн их үнэ хүргэж болох газраа нэвтрүүлэх ба гадаадаас авч ирэх барааг аль улсад боловсруулсныг хэрэгсэхгүй, гагцхүү чанар сайн, үнэ бага агаад харьяат олон ардын хэрэглэх, дурлах явдалд тавтайяа нийцүүлэхийг нь сонгон бэлтгэн авч ирнэ. Оросын аж ахуйн газруудаас эл манай худалдааны бодлогод саад боогдол учруулж устгахыг хичээх нь олон ардын туйлын ашиг тус ба манай хувьсгалт улсын аливааг үйлдэх боловсруулах хэрэг явдалд их л хор болно». (20) гэсэн байдаг.

1925 оны 9 дүгээр сарын сүүлчээр Москва хотноо шинээр томилогдсон Онц бөгөөд бүрэн эрх барих элчин төлөөлөгч, гүн Бүрдийн Буянчуулган Францийн элчин сайд Ж.Эрбет²⁰ лугаа өөрийн Элчин яамнаа биеэр уулзаж, хоёр орны харилцаа, тухайлан боловсрол, соёл, судалгаа, шинжилгээний салбарт хамтран ажиллах талаар санал солилцож, цаашлаад дипломат ноот бичиг харилцан илгээж байсан нь хоёр орны найрсаг харилцааны ойрхи үеийн түүхийн торгон эх болж байна.

Энэ уулзалтын тухайд Москва дахь Францын ЭСЯ-наас ГХЯ-ндаа мэдэгдсэн цахилгаан утсанд: «Монгол улсын шинэ элчин Буянчуулган Москвад 9 дүгээр сарын 27-нд хүрэлцэн ирээд 28-ны өдөр Ерөнхийлөгч Калининд итгэмжлэх жуух бичгээ гардуулав. Дараа тэрбээр Элчин төлөөлөгчдийн бүх газруудын тэргүүн нартай уулзав. Би түүнтэй Москва мөрний эрэг дэх жижигхэн байшинд нь уулзсан. Түүний ирсэн зорилго ба хэлсэн үгийнх нь өнгө аяс их сонирхол төрүүлэв... Байдал төрөхөөс нь харвал Бүрэн эрхт тусгаар улсыг төлөөлж байгаа мэт. Төлөөлж байгаа улсыг нь Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэдэг, тэгээд ч түүний хэлж буй үг яриа, төлөөлөгчийн газрынх нь гаднах байдал цөмөөрөө Монгол Хятадаас тусгаар гэдгийг гэрчилж байна... Ноён Буянчуулган Францад Монгол оюутнуудыг сургаж, Монголд Францын эрдэмтэн судлаачдыг эрдэм шинжилгээний ажил хийлгэхээр

20 Herbet, Jean Jules (1878-1953), дипломатч, 1924-1927 онд Москвад элчин сайдаар ажиллаж байхдаа Монгол-Францын харилцааг хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргаж байжээ.

хүсэлт тавьсан. Тэрбээр ирэх жил өөрөө Парист очих санаатай юм байна» гэж мэдээлжээ.

Францын элчин сайд Эрбет Монголын элчин төлөөлөгч Буянчуулганд «ЗХУ-ын Засгийн газрын дэргэд БНМАУ-ыг төлөөлөн суугаагийн хувьд ЗХУ-д суугаа Францын элчин сайд түүнтэй харилцаж байгаа бөгөөд тэр утгаараа Франц улсын Засгийн газарт суугаа БНМАУ-ын төлөөлөгч болж байна»²¹ гэж цохон тэмдэглэсэн байна. Нөгөөтэйгээр элчин сайд Эрбет Дээд-Үд-Хиагт-Улаанбаатарын хооронд баригдах төмөр зам, түүнийг Хаалган хүртэл үргэжлүүлэх эсэх талаар сонирхон Улаанбаатар, Хаалганы хооронд төмөр зам барих эрхийг америкчуудаас авахыг өөрийн Засгийн газартаа санал болгоход бэлэн байгаа тухай дурдаж байжээ.

Элчин Б. Буянчуулганаас 1925 оны сүүлчээр ГЯЯ-нд ирүүлсэн 172 тоот нууц мэдээнд: «Эдүгээ Герман, Франц, Англи, Итали, Австри зэрэг улс, улстөр, харилцан худалдааны холбоотой болох байдал сэдэв буй мэт. Бас ч тус бүр эрдэмтэн төлөөлөгчийг одуулж шинжлэн үзмой. Мөн нэгэн адил үзхүл таны бие /ГЯЯ-ны сайд Д.У./ буюу төлөөлөгчийг тус тус илгээвээс эрх биш бидний Засгийн газраас хүндэтгэн хүлээн тусалмой хэмээмой. Жич. Эл учрыг нөхөр Л.Карахантай хэлэлцвээс түүний хэлэх нь энэ хэргийг оролдон хэлэлцвээс нэн сайн» гэсэн архивын тун сонирхолтой баримт байна.²²

3. Монгол, Өрнөдийн худалдааны харилцаа

1920-иод он бол Монгол, Өрнөдийн хоорондын худалдааны харилцааны оргил үе байсан гэж үзэж болохоор байна. 1924 онд бэлтгэл ба экспортод худалдааны янз бүрийн байгууллагуудын эзлэхувийн жин дор дурдсан харьцаатайгаар илэрхийлэгдэж байжээ.

Монголын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байсан Америк, Английн пүүсүүд нь ахар богино хугацаанд худалдааны томоохон пүүсүүд болтлоо өсчээ. Анхлан Лейпцигийн компани байж байгаад Английнх болсон “Biedermann” хэмээх худалдааны пүүсийн жилийн гүйлгээ нь 990 мянган мексик доллар²³, АНУ-ын Харбин дахь

21 ГХТА. Ф.01. ХН.360

22 ГХТА. Ф.01. ХН.359 элчин сайд Б.Буянчуулганы 172 тоот нууц шифр. 1925 он

23 1895 онд байгуулагдаж Дорнод Хятадын Төмөр Замын гол санхүүг барьдаг, Орос-Хятадын банкны Шаньхайн салбараас анх (1910 оноос Орос-Азийн банк болсон) гүйлгээнд гаргасан мексик долларын 1, 5, 10, 50, 100-тын дэвсгэрт 1930 он хүртэл Монгол Улсын гадаад төлбөр тооцооны гол хэрэгсэл байжээ.


“International Export” хэмээх салбарын пүүсүүд 752 мянган мексик доллар, Тяньжиний “International Export” хэмээх салбарын пүүсүүд 748 мянган мексик доллар, “Brenner Brothers” пүүс 392 мянган мексик доллар болж байжээ.

1920-иод оны үед Монголд Германы 5 орчим пүүс худалдааны үйл ажиллагаа явуулж байсны дээр Монголын Харилцан Туслалцах Хоршоо /МХТХ/ Германтай худалдаа хийж, 1925, 1926 онд нийт 4 сая 114 мянга 400 төгрөгийн барааг худалдан авчээ. (21)

Монголын зах зээл дээр 1927 оны байдлаар МХТХ болон гадаадын компаниудын худалдаа хосолж тэдгээрийн 18 сая 353 мянга гаруй мексик доллар гүйлгээнд эргэлдэж байв.

Үүнийг тус бүрээр нь авч үзвэл МХТХ 3 сая 900 мянган мексик доллар, Монголын Худалдаа, Аж Үйлдвэрийн Банк /хувь нийлүүлсэн үндсэн хөрөнгө оролцуулахгүйгээр/ 1 сая 267 мянган мексик доллар, Оросын харьяат хувийн худалдаачдын 46 пүүсийн 704,500 мексик доллар буюу нийт дүнгээрээ 5 сая 871,500 мексик доллар болж байв.

Зураг 1.



Зураг 2.




Эх сурвалж: “Хозяйство Монголии”
1926 г. №2, с. 164-165.

Эх сурвалж: “Хозяйство Монголии”
1928 г. №1, с. 27.

Хятадын худалдаачдын 283 пүүсийн зах зээлийн нийт эргэлт нь 7 сая 248 мянган мексик доллар, Английн худалдааны 10 пүүсийн 4 сая 500 мянган мексик доллар, Америкийн таван пүүсийн 560 мянган мексик доллар, Германы 5 пүүсийн 173 мянган мексик доллар буюу гадаадын бүх капитал нийт дүнгээрээ 12 сая 481 мянга 500 мексик долларт хүрч байсан нь тус улсын гүйлгээний 66,1 хувийг эзэлж байсан байна. (22)

Зураг. 3



Эх сурвалж: УТТА. Ф. 91. Т. 27.ХН.13

1923-1937 онд Монголд үйл ажиллагаа явуулж байсан Германы «АО[Акционерное Общество] Востваг» хэмээх хувьцаат нийгэмлэг (WOSTWAG-West-Osteuropaeische Warenaustausch Aktiengesellschaft-AG West-Far Eastern Trade Exchange Joint Stock Society)-ийн жил бүрийн тайлангийн тоо, баримтаас харахад Монгол Улсын гадаад худалдаанд маш том байр суурь эзэлж байв.²⁴

Эдгээр баримт бол Монголын удирдагчид ЗХУ-аас гадна «гуравдагч» гүрнүүдтэй худалдаа, соёлийн хэлхээ, холбоо тогтоох чин эрмэлзэлтэй байсныг харуулж байгаа юм.

Хэдийгээр ЗХУ болон Коминтерны зүгээс БНМАУ-ын гадаад, дотоод бодлогыг өөрийн чиг шугамд захируулах арга хэмжээ авсаар байсан боловч Монголын Улс төрийн удирдах зүтгэлтнүүд нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгааг үл харгалзан өндөр хөгжилтэй АНУ, Өрнөд Европын зарим оронтой худалдаа, соёлын харилцаа тогтоон хөгжүүлэх чиглэлийг баримталсаар байжээ.

Тухайн үеийн Монголын Улс төрийн зүтгэлтнүүдийн баримталж байсан дээрх чиг шугам тодорхой амжилтад хүрч байсныг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

24 Д.Уламбаяр. «Германы “Востваг” хувьцаат нийгэмлэг, түүний Монгол дахь үйл ажиллагаа»-“Олон улс судлал” сэтгүүл, ШУА-ийн ОУСХ, 2013, №4(101), 39-55 дахь тал

4. Монголын «гуравдагч байгалийн хөршүүд», тэдний үйл ажиллагаа, мөн чанар

Нэгд, Алс Дорнодын зүгээс гадаадын гүрнүүд цэргийн интервенц хийх үед Зөвлөлт Засгийн газар цэрэг-стратегий, аюулгүй байдлын үүднээс 1920 оны 4 дүгээр сарын 6-нд Верхнеудинск (одоогийн Улаан-Үд, 10 дугаар сараас нийслэл нь Чита болсон) хотоор төвлөрсөн шинэ «хөрш» Үндсэн хууль (1921 оны 4 дүгээр сарын 27-нд батласан Д.У), төрийн сүлд, туг далбаа, Засгийн газар, ГЯЯ, мөнгөн дэвсгэрт, шуудангийн марктай de facto бие даасан АДБНУ хэмээх «буфер»-ыг Монголтой хил залгаа чанх хойд хэсэгт байгуулж²⁵, гадаадын интервенци болон Оросын иргэний дайн дууссаны дараа 1922 оны 11 дүгээр сарын 15-нд «буфер»-ээ татан буулгасан юм.²⁶ АДБНУ-ыг Өрнөдийн хэвлэлүүдэд Chita Republic гэж бичиж байсан юм. АДБНУ-ын анхны ГЯЯ-ны сайдаар БХК(б)Н-ын ТХ-ны Алс Дорнодын Товчооны дарга Б.З.Шумяцкий томилогдон ажиллаж байгаад 1921 оны 3 дугаар сараас ЗОУ-ын ГХАК-аас Монгол дахь Ажилчин-тариачны улаан армийн салбар анги, Ардын Түр Засгийн газар, 7 дугаар сараас

25 Москва АДБНУ-аар дамжуулан Гадаад Монголын ирээдүйн статусын тухай Бээжингийн байр суурийг тандахыг оролдож байв. Тэгэхдээ Зөвлөлтийн дипломат алба Хиагтын системийн зарчмыг Зөвлөлт хувилбараар тухайлбал «Хятадын сюзеренитетийн (suzerainete-хэмжээг эзэрхэх гэсэн франц үг ажээ Д.У) дор автономит Монголыг сэргээхийг» иш үндэс болгож байжээ. Москва АДБНУ-ын удирдлагатай зохицуулснаар сайхь улсын ГЯЯ-ны сайд И.Л.Юрины байр суурийг нотлон Бээжингийн Засгийн газарт 1921 оны 8 дугаар сард мэдэгдэл хийж, түүндээ: «Монголын байдлыг Монголын талаар хуучин Хаант Орос ба Хятадын гэрээгээр тодоройлох болно, АДБНУ Хятадаас Монголыг тусгаарлахад үл хүргэнэ» гэж мэдэгдэж байсан бөгөөд үүнийг нь ч Бээжин хариултгүй үлдээсэн нь Монголыг шууд өөрийн бүрэлдэхүүнд авах бодлоготой нь холбоотой байв.

26 Юдин, Виталий Иванович. (1890-1961) Зөвлөлтийн дипломатч, тусгай албаны ажилтан, эрдэмтэн. 1920 оны 10 дугаар сараас Монголтой хил залгаа бүсэд АДБНУ-ын Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгч, 1921 оны 7 дугаар сараас 12 дугаар сар хүртэл АНБНУ-ын ГЯЯ-наас Монголд суугаа Бүрэн эрх барих элчин төлөөлөгч бөгөөд Монгол дахь Ажилчин-тариачны улаан армийн салбар ангийн дэргэд суугаа Бүрэн эрхт төлөөлөгч, 1922-1925 онд ЗХУ-аас Монгол Улсад суугаа Бүрэн эрхт төлөөлөгчийн газрын анхны I нарийн бичгийн даргаар ажиллаж байв. Дорнод Сибирийн Эрхүү мужид төрсөн, Эрхүүгийн их сургуульд суралцаж байгаад хувьсгалт үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, баривчлагдан цөлөгдөж байжээ. Сүүлд 1931 онд Ленинградын их сургуулийн философийн факультетийг дүүргэсэн. 1935 онд профессор, 1936 онд философийн ухааны докторын зэрэг хамгаалж, 1939 онд ШУА-ийн сурвалжлагч гишүүн, КУТВ-г багшилж байгаад хэлмэгдэж, 10 жилийн ял сонссон. Сүүлд цагаадсан. 1953 онд ШУА-ийн академич, 1939-1944 онд ШУА-ийн философийн хүүрээлэнгийн захирал, 1943 онд Сталины шагнал хүртсэн. 1944-1948 онд Москвагийн улсын их сургуулийн марксизм-ленинизмын тэнхимийн эрхлэгч, 1948-1953 онд Герман дахь Зөвлөлтийн хяналтын комисст улс төрийн зөвлөх, Герман дахь ЗХУ-ын Дээд комиссарын орлогч, 1952-1959 онд ЗСБНХУ-аас БНХАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, 1961-1963 онд ЗХУ-ын ШУА-ийн Тэргүүлэгч гишүүнээр ажиллаж байв. Түүний бичсэн «У истоков Монгольский Народный Революции: Из воспоминаний и документов» өгүүлэл нь ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгээс эрхлэн 1959 онд Москвад хэвлүүлсэн “Монгольский Сборник: Экономика, история археология” хамтын бүтээлд орсон.

АЗГ-ын дэргэд суугаа Бүрэн эрхт төлөөлөгч, түүний орлогчоор хожим БНМАУ-д суугаа Бүрэн эрх барих элчин төлөөлөгчөөр 1927-1933 онд ажиллаж байсан А.Я.Охтин нар ажиллаж байв.

Хоёрт, 1921 оны 8 дугаар сарын 14-нд ЗХУ, Коминтерны идэвхтэй явуулгаар «Бүгд Найрамдах Тагна-Тыва Ард Улс»-ыг тунхаглан зарлаж, 22 зүйл бүхий Анхдугаар Үндсэн хуулийн төслийг хэлэлцэн баталж, Засгийн тэргүүнээр гүн Монгуш Буян Бадьргы (1892-1932) сонгогджээ. 1926 онд Тагна-Тыва буюу Урианхайн хуучин нийслэл Белоцарск хот буюу 1918 онд өөрчилөн нэрлэсэн Хем-Белдир хотыг Кызыл (тува хэлээр Улаан гэсэн утгатай ажээ Д.У) хэмээн нэрлэж дахин өөрчилжээ. Тийнхүү Монгол нь хойд талдаа монгол угсааны эсгий туургатан Тагна-Тыва хэмээх шинэ «гуравдагч хөрш»-тэй болж, 1925 оны 6 дугаар сард ЗХУ хүлээн зөвшөөрч, ЭСЯ-ны хэмжээнд дипломат харилцаа тогтоожээ.

Тийнхүү 1925 оны 11 дүгээр сард хуралдсан БНМАУ-ын II Их хурлаас илгээлт явуулж Бүгд Найрамдах Тагна-Тыва ард улсыг хүлээн зөвшөөрснөө мэдэгджээ. Улмаар БНТТАУ-ын Засгийн газрын төлөөлөгчид Монголд айлчилж «Монгол ба Тагна Тыва хоёрын хооронд Найрамдлын холбоо байгуулах тухай» 12 зүйлт бүхий Гэрээ бичгийг 1926 оны 8 дугаар сарын 16-нд Улаанбаатар хотноо байгуулж, БНМАУ-ыг төлөөлж ГЯЯ-ны сайд В.Дорлигжав, Бүгд Найрамдах Тагна Тываг (Тува Д.У) төлөөлж Дарамбазар, Санжаа нар гарын үсэг зуржээ. Энэхүү гэрээгээр хоёр улс ЭСЯ-ны хэмжээнд дипломат харилцаа тогтоожээ.²⁷ (23) Тагна-Тывагийн нутаг дэвсгэр нь Монголын газар нутгийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг Урианхайн хязгаар байсан билээ. 1944 оны 10 дугаар сарын 11-нд БНТАУ нь ЗСБНХОУ-ын бүрэлдэхүүнд нэгдэж, автономит муж болсноор хоёр улсын элчин харилцаа дуусгавар болжээ. (24)

Гуравт, БНМАУ-ын дорнод хэсэгт 1932 оны 2 дугаар сарын 18-нд Японы идэвхтэй дэмжлэг, оролцоотой өөр нэг шинэ «гуравдагч хөрш» Манжго байгуулагдаж, тус улстай нийт 700 км урт газраар

27 БНМАУ-аас БНТАУ-д сууж байсан элчин сайдууд: Самбаа 1928-1929, М. Дугаржав 1929-1931, Заяат 1932-1934, Д. Догсом 1934-1935, Гомбожав 1935-1936, Д. Намсрай 1936-1937, Шагдар 1937-1939, М. Дугаржав 1939-1941, Н. Ядамжав 1941-1944, БНТАУ-аас БНМАУ-д Х. Ананд 1928-1929, О. Харцага 1929-1931, К. Сунгар-Оол 1931-1935, Достай-Оол 1935-1936, Ш. Лувсанбуу 1936-1937, И. Балдан-Оол 1937-1938, Х. Намсрай 1938-1941, О. Охэмчиг 1941-1943, И. Бадраа 1943-1944 он

шууд хиллэх болсон нь хэрэг дээрээ Японтой хаяа хатгаж «зэрэгцэн оршиход» хүрэв. Манжго-г Герман, Японы нөлөөнд байсан болон Төв Америкийн нийт 18 улс албан ёсоор хүлээн зөвшөөрснөөс гадна ЗХУ de facto хүлээн зөвшөөрсөн байна.²⁸ Манжго Тагна-Тыватай харьцуулахад бодлого, зорилго чиглэл нь тэс өмнөө байсан юм. Халхын сүмийн хилийн маргаанаас шалтгаан 1935-1937 онд Манжго-БНМАУ-ын хооронд Манжуурт нижгээд удаа цуврал бага хурал болж, энэ үеэр Манж-го улсын талаас дипломат харилцаа тогтоох санал тавьж, 1940 оны 6 дугаар сард Манжго-БНМАУ-ын хилийн шугам тодотгох нэг талаас ЗХУ, БНМАУ, нөгөө талаас Япон, Манжго-гийн 4 талын холимог комиссын Москвагийн хэлэлцээр явагдаж 1941 оны 10 дугаар сард дуусгавар болсон, 1941 оны 4 дүгээр сарын Зөвлөлт-Японы төвийг сахих гэрээ зэргийг энд дурдаж болно. (25) 1932 оны 4 дүгээр сард Зөвлөлт Хятадын Түр Засгийн газар (1931 оны 11 дүгээр сард Төв Хятадын өмнөд хэсэгт ХКН-ын удирдлага дор байгуулагдсан Хятадын Зөвлөлтийн БНУ 1937 оны 9 дүгээр сар хүртэл оршин тогтножээ.²⁹ Тус дагуул улс нь өөрийн туг далбаа, үндэсний мөнгөн

28 Д.Уламбаяр. Монгол Улс ба Алс Дорнодахин: Олон улсын харилцаа, геополитик, дипломат ажиллагаа. XX зууны эхнээс XXI зууны эхэн. Тэргүүн боть. УБ., 2013, 361 дэх тал, Токиогийн гэрээ буюу 1933 оны 5 дугаар сараас Токио дахь Зөвлөлтийн элчин сайд Констатин К.Юренев, Японы ГЯЯ-ны сайд Коки Хирота нарын удаа дараагийн уулзалт, ДХТЗ-ын Удирдах Зөвлөлийн дэд Ерөнхийлөгчийн орлогч П.А.Бандур, ДХТЗ-ын Удирдах Зөвлөлийн Ерөнхийлөгч Ли Шаогэн нарын хооронд удтал үргэлжилсэн хэлэлцээний дунд 1935 оны 3 дугаар сарын 23-нд Токиод гарын үсэг зурсан «ЗСБНХУ ДХТЗ-ыг Манж-Го-д худалдах тухай Хэлэлцээр»-(орос, англи хэл дээр), түүний хавсралт болох ЗСБНХУ, Японы хооронд мөн өдөр байгуулсан нууц протоколын дагуу ЗХУ ДХТЗ-ыг Манжгод 140 сая иен буюу 120 сая алтан рублиар худалдаж, үүний гуравны нэгийг бэлэн мөнгөөр, үлдсэнийг зөвлөлтийн захиалгаар японы компаниудад бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, 30 сая иенийг ДХТЗ-д ажилладаг зөвлөлтийн ажилчин, албан хаагчдын цалин, тэтгэвэрт зориулахаар тохиролцож, тийнхүү 1435 км үргэжилсэн ДХТЗ ЗХУ-ын эзэмшлээс Манжгогийн мэдэлд бүрэн шилжжээ. Үүгээр ЗХУ Манжгог de facto хүлээн зөвшөөрчээ. Токиод байгуулсан 14 зүйл бүхий дээрх гэрээнд ЗХУ-ын талаас Японд суугаа элчин сайд К.К.Юренев, ГХАК-ын хэлтсийн эрхлэгч Б.И. Козловский, ДХТЗ-ын Удирдах Зөвлөлийн Шадар дарга (Товарищ Председатель) С.М.Кузнецов, Манж-Го-гийн талаас Японд суугаа Манж-Го-гийн элчин сайд Дин Шиноань (В.С.Дин), Манж-Го-гийн ГЯЯ-ны Шадар сайд (Товарищ Министр) Чуичи Охаси, ДХТЗ-ын Ерөнхий захирлын зөвлөх У Цзэшен нар гарын үсэг зурж, Японы ГЯЯ-ны сайд Коки Хирота байлцжээ. «Соглашение между СССР и Маньчжоу-Го об уступке Маньчжоу-Го прав СССР в отношении Китайской Восточной железной дороги (Север-Маньчжурской железной дороги)» Токио 23 марта 1935 г.

29 ХКН-ы ирээдүйн удирдагч Мао Цзедун, Чжү Дэ нарын санаачлан 1931 оны 11 дүгээр сард Хятадын БНУ-ын дотор байгуулж, 1937 он хүртэл оршин тогтносон байна. Энэ ажиллагаанд ЗХУ оролцсон. Нийслэл нь 1931-1936 онд Жуйцзинь хот байжээ. Энэ «тоглоомын» улсын нутаг дэвсгэрт албан бусаар Зүүн хойд Жяньси (Jiangxi), Хунан-Жяньси (Hunan-Jiangxi), Хунан-Хубэй-Жяньси (Hunan-Hubei-Jiangxi), Хунан-Өрнөд Хубэй (Hunan-Western-Hubei), Хунан-Хубэй-Шичуань (Hunan-Hubei-Shichuan-Guizhou), Шаньси-Гансу (Shaanxi-Gansu), Шичжуань-Шэньси (Szechuan-Shensi), Хубэй-Хунан-Аньфу (Hubei-Hunan-Anfu), Хоньху (Honghu), Хайфэн-Луфэн (Haifeng-Lufeng) харьяалагдаж байв. Энэхүү улс доторх улсын «ерөнхий сайд»-аар Мао Цзедун ажиллаж байжээ. Лениний хөрөгтэй Хятадын Зөвлөлт БНУ гэсэн мөнгөн дэвсгэргийг гүйлгээнд гаргаж, үндэсний татварын албатай, шуудангийн марктай, мөн Коминтерн идэвхтэй дэмжиж байжээ.

дэвсгэрт, шуудангийн марктай байсан бөгөөд 1934 оны 1 дүгээр сард нийслэл Жуйцзинь хотноо хуралдсан Бүх Хятадын Зөвлөлүүдийн II их хурлаас өөрийн Үндсэн хуулийг эцэслэн хэлэлцэн баталж, БНМАУ-ын тусгаар тогтнолыг үг дуугүй хүлээн зөвшөөрч байгаагаа мэдэгдсэн юм.Д.У)³⁰ Манж-го болон Японд дайн зарласан юм.

Дөрөвт, 1944 оны 11 дүгээр сарын 12-нд Кульжа хотод Зөвлөлтийн нөлөө бүхий Дорнод Туркестаны Хувьсгалт Бүгд Найрамдах Улсыг тунхаглажээ. 1949 оны 9 дүгээр сар хүртэл de facto оршин тогтнож байсан тус улсын нутаг дэвсгэрт Шиньжан-Уйгурын баруун хойд мужийн Иль, Тарбагатай, Алтай гурван аймаг харьяалагдаж байв. Өрнөдийн болон оросын түүхэнд түүнийг Хоёр дахь Дорнод Туркестаны Бүгд Найрамдах Улс хэмээн тэмдэглэж байв. Шиньжан-Уйгурын хойд Алтайн хязгаар (Ашан хошуу) нь (төв нь Шарсүм буюу Чэнхуа) БНМАУ-ын Баян-Өлгий, Ховд аймагтай 1500 км орчим газар нутгаар шууд хиллэж байв. 1945 оны 9 дүгээр сар гэхэд Зөвлөлтийн консулын тусламжтайгаар Оспан батыр (Осман Ислам-улы буюу Оспан батыр) Алтай аймгийн амбан (жицүн) сайдад, түүний орлогчид Далелхан Сугарбаев нар томилогдсон байна. 1945 оны 4 дүгээр сард Дорнод Туркестаны үндэсний арми байгуулагдаж, ерөнхий командлагчаар Зөвлөлтийн хошууч генерал Иван Г. Полинов, орлогчоор нь хурандаа Ф.И.Лескин томилогдсон байна. Дивизийн даргаар нь монголын казах гаралтай Далелхан Сугарбаев ажиллах болжээ.

Гэвч энэ улсын ирээдүйн хувь заяа Москвад 1945 оны 8 дугаар сарын 14-нд ЗСБНХУ, Хятадын БНУ-ын хооронд байгуулсан найрамдал, холбоотны гэрээгээр шийдэгдсэн байна. ЗХУ-ын Гадаад явдлын ардын комиссар В.М.Молотов, Хятадын Гадаад хэргийн сайд Ван Шизе нарын гарын үсэг зурсан гэрээний V зүйлд: Хятадын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, дотоод хэрэг хөндлөнгөөс үл оролцох,

30 Программные документы китайских советов. Сборник М.: Партиздат. ЦК ВКП(б), 1935 г. с. 50-53 “1931 оны 11 дүгээр сард Цзянси мужийн Жуйцзинь хотод болсон Бүх Хятадын Зөвлөлүүдийн анхдугаар их хурал үндэсний асуудлаар гаргасан VI зүйлийн а-д «Хятадын Зөвлөлт Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуулинд Хятадын Зөвлөлт Бүгд Найрамдах Улс, БНМАУ-ын тусгаар тогтнолыг үг дуугүй, бүрэн гүйцэт хүлээн зөвшөөрч байгаагаа яруу тод заасан байвал зохино» гэжээ. «Хятадын Зөвлөлт Бүгд Найрамдах Улс, үндэсний хувьсгалт хөдөлгөөн ба жишээ нь БНМАУ зэрэг империализм, гоминьданы милитаристуудын эсрэг гэмцэж тусгаар тогтнолоо олж авсан үндэстэнгүүдийг дэмжих болно» гэжээ. 1934 оны 1 дүгээр сард Бүх Хятадын Зөвлөлүүдийн II их хурлаас «Хятадын Зөвлөлт Бүгд Найрамдах Улсын Түр Үндсэн хуульд Хятадын Зөвлөлт Засаг нь жижиг үндэстнүүдийн өөрийгөө тодорхойлох эрхийг монгол мэтээр бүр биеэ даасан улс байгуулах хүртэл нь зөвшөөрөн хүлээнэ» гэжээ.

түүний бүрэн эрхийг хүндэтгэх зарчмыг удирдлага болгон өндөр дээд түвшинд тохиролцов гэсэн байна. 1945 оны 9 дүгээр сард Чан Кайши хувьсгалт гурван аймагт автономит эрх олгох тухайгаа мэдэгдсэн байна. ЗХУ-ын удирдлага Дорнод Туркестаны эрх баригчдыг Хятадын Гоминьданы намынхантай хэлэлцээрийн ширээний ард хүчлэн суулгав. Хэлэлцээр Шиньжан дахь Гоминьданы захирагч генерал Жан Жижун, Дорнод Туркестаныг төлөөлж Ахметжан Касымов нарын хооронд 3 сар гаруй хугацаанд үргэлжилсний эцэст 1946 оны 1 дүгээр сарын 2-нд «11 зүйлт хэлэлцээр»-т гарын үсэг зурж, эвслийг Засгийн газар байгуулжээ. Эвслийн Засгийн газарт Оспан батыр яамгүй сайд бөгөөд Алтай аймгийн амбан (жицүн) сайдаар дахин баталсан байна. Дээрх хэлэлцээрээр Дорнод Туркестаны БНУ-д хэлний тэгш байдал, үг хэлэх, хэвлэн нийтлэх, жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, дотоод, гадаад худалдааг бие даан эрхлэхээс гадна өөрийн үндэсний зэвсэгт хүчнээ хадгалж үлдэх эрхийг олж авсан байна. 1946 оны 6 дугаар сард Чан Кайши «11 зүйлт хэлэлцээр»-ийг баталсан байна. 1947 оны 7 дугаар сард Шиньжаны Эвслийн Засгийн газар задран унажээ.

1949 оны 9 дүгээр сард ХАЧА-ийн цэргүүд Өрөмчи хотыг чөлөөлж, хяналтаа тогтоожээ.

1949 оноос Өрөмч дэх Дорнод Туркестаны Засгийн газрыг татарын большевик Бурхан Шахиди тэргүүлжээ. 1955 оны 10 дугаар сарын 1-нд БНХАУ-ын бүрэлдэхүүнд Шиньжан-Уйгурын өөртөө засах орны статустай болсон билээ.

1940-өөд онд БНМАУ-ын баруун хилийн чанад Алтайн уулсын өвөр нутагт Хятадын захиргаадлыг эсэргүүцэн өрнөсөн Шиньжаны казакчуудын үндэсний чөлөөний хөдөлгөөний гол нэгэн толгойлогч. Оспаны үйл ажиллагааны салшгүй хэсэг нь Монгол улстай түүний эерэг, сөрөгөөр харилцаж байсан харилцаа юм. Маршал Х.Чойбалсан Оспантай найрсаг харилцаа тогтоон дэмжих бодлого баримталж байсан нь ЗХУ-ын бодлогын илрэл хэдий боловч Монголын тусгаар тогтнолыг ямагт эрхэмлэж, түүнд учирч болзошгүй Хятадын аюулаас сэрэмжлэх явдалтай шууд холбогдож байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Гэхдээ дээрх нь Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлоготой огт холбогдолгүй шинээр буй болсон «байгалийн хөршүүд», их гүрнүүдийн халхавч «тоглоомын улс» байсан юм.

Коминтерний шууд удирдлага дор 1928 оны 10-12 дугаар сард хуралдсан МАХН-ын VII их хурал Ц.Дамбадорж, Н.Жадамба, А.Амар, Ж.Цэвээн, Ц.Дашсампилон зэрэг улс төрийн олон удирдагчдыг хөрөнгөтөн орнуудтай дотносох гэсэн, «Баяжигтун» лозунг санаачлагч, ЗХУ-аас хөндийрөх гэсэн гэж хурц шүүмжлээд «Баруунтан» хэмээн цоллож, намын удирдлагаас гаргасан байна. Их хурлын дараа «Баруунтныг» илчлэх, намыг цэвэрлэх өргөн хэмжээний кампанит ажил өрнөж гадаадын иргэд, капиталыг Монгол Улсаас дэс дараатай шахан гаргаж эхэлжээ. БХК(б)Н, Коминтерн болон зүүнтний ажил явуулгын үрээр Монгол Улсын Засгийн газар 1930 оны 12 дугаар сард гадаад худалдаанд улсын онц хэрэг тогтоосноор Монгол Улсын эдийн засаг дан гагц нэг орноос хамааралтай болохын эх үндэс тавигдаж Зөвлөлтийн тойрог замд орсноор дагуул улс болох эхлэл тавигдсан байна. Гадаад худалдаанд улсын онц эрх тогтсоноор гадаадын компаниуд тус улсад үйл ажиллагаа явуулах ямар ч бололцоогүй болж, Монголын эдийн засгаас шахагдан гарчээ. Гадаад худалдаанд улс монополь эрх тогтоосон нь 1929 оны 6 дугаар сарын 25-нд Улаанбаатарт гарын үсэг зурсан «Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Холбоот Улс ба БНМАУ хоёрын хоорондын үндсэн зүйлүүдийг батлан тогтоосон Гэрээ бичиг» хэмээх маш нууц [зэрэглэлтэй Д.У] хэлэлцээртэй шууд холбоотой байв. Гэрээ бичигт: «СССР нь Монголыг, Монгол нь СССР-ийг ийнхүү онцоор үзсэн лүгээ адил бусад гадаад улсыг үзэх болсон нь хоёр этгээдийн уул бодлого зорилго лугаа үл нийцэх тул аливаа гадаад улсууд ба тэр улсуудын харьяат нарт тийнхүү онцоор үзэх явдлыг үл дэлгэрүүлэхийг хоёр этгээдээс батална» гээд БНМАУ нь зөвхөн ЗХУ-д бараа бүтээгдэхүүнээ экспортлож, зөвхөн ЗХУ-аас бараа, бүтээгдэхүүн импортлох, ЗХУ-д үйлдвэрлэдэггүй бүтээгдэхүүнийг зөвхөн ЗХУ-ын нутгаар дамжуулан оруулж байхаар заасан байна. Энд Монголын зах зээлийг ямарч өрсөлдөөнгүй дангаар эзэгнэх гэсэн ЗХУ-ын эдийн засгийн сонирхлоос гадна Монголыг гадаад ертөнцөөс бүрэн тусгаарлах гэсэн улс төрийн бодлого зэрэгцэн явсан байна. Энэ хэлэлцээрт анх удаа Зөвлөлтийн сургагч, зөвлөхүүдийн тухай тусгагджээ. Дурьдсан

хэлэлцээрт Монголын талаас Ерөнхий сайдын жинхэнэ орлогч бөгөөд ААЯ-ны сайд Ж. Дамдинсүрэн, ГЯЯ-ны сайд Ц. Гүрсэд, УБХ-ын гишүүн П. Гэндэн, Зөвлөлтийн талаас Бүрэн эрх барих элчин төлөөлөгч Андрей Яковлевич Охтин, ЗХУ-аас БНМАУ-д суугаа худалдааны төлөөлөгч Ефим Григорьевич Ботвиник, ЭСЯ-ны 1 дүгээр нарийн бичгийн дарга Анатолий Яковлевич Климов нар гарын үсэг зуржээ. 1930 оны 12 дугаар сард гадаад худалдаанд улсын онц эрх тогтоосноор Монголоос гадаадын пүүс, капитал бүрмөсөн шахагдан гарсан байна. Энд Монголын зах зээлийг ямарч өрсөлдөөнгүй дангаар эзэгнэх гэсэн ЗХУ-ын геоэдийн засгийн сонирхлоос гадна Монгол Улсыг гадаад ертөнцөөс бүрэн тусгаарлах гэсэн геополитик зэрэгцэн явсан байна. Дурдсан гэрээ бичгийг хүчингүй болгож байгаагүй юм. (26)

ДУГНЭЛТ

Нэгд: 1911 оны тусгаар тогтнолын сэргэлтийн дараа Монголын улс төрийн удирдагчид хоёр хөршөөс гадна гуравдагч гүрнүүдэд ихээхэн ач холбогдол өгч байсан нь гадаад улс төр, худалдаа, соёлын бодлогын чухаг чиг шугам байжээ. Энэ нь юуны өмнө Өрнөдийн гүрнүүдээр өөрийн тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх, тэдгээр орнуудтай худалдаа, соёл-боловсролын өргөн харилцаа холбоо тогтоох, Өвөр чуулганыг Халхад нэгтгэх замаар Монголын улс төрийн нэгдлийг хангах явдал байв. 1911-1930 он бол Монгол Улсын гадаад харилцааны түүхэнд «гуравдагч» гүрнүүдтэй холбоо харилцаа тогтоох, тэдний тусламж дэмжлэгийг олж авахыг үнэнхүү эрмэлзэж байсан үе хэмээн үзвээс зохилтой. Гэвч үүнд саад болж байсан хүчин зүйлүүдийн гол учир нь Монгол-Оросын харилцаан дахь Хятад, Орос-Хятадын харилцаан дахь Монгол, Монгол-Хятадын харилцаан дахь Орос гэгчлэн харилцан хамааралтай боловч, ялгаатай эрх ашиг, сонирхол хосолсон гурвалжин бий болсон явдал юм. Энэхүү эрх ашиг, сонирхол нь нэгд, хэзээ ч Хятадын бүрэлдэхүүн хэсэг байгаагүй туурга тусгаар Монгол Улсын хууль ёсны бүрэн эрхт байр суурь, хоёрт, Монголыг халхавч, бамбай байлгах гэсэн Хаант Орос, дараа нь ЗХУ-ын империйн хэдийнээс баримталж ирсэн геополитик, гуравт, Монголыг Хятадын салшгүй хэсэг гэж үзэж байсан Өмнөд хөршийн илэрхий бусармаг явуулга, байр суурь байв. Энэхүү гурвалжинд Японы

хүчин зүйл тодорхой байр суурь эзэлж байсан юм. Эцэст нь, дурдсан гурвалжинд нөлөө үзүүлж байсан голлох оролцогч нь АНУ байсан гэдгийг тэмдэглэвэл зохино. Ер нь АНУ Монголын тусгаар тогтнолыг албан ёсоор шууд эсэргүүцэн татгалзсан юм уу, эсхүл энэ асуудлыг огт авч хэлэлцэхээс татгалзаж байгаагүй гэдгийг эх сурвалж нотолдог.

АНУ-аас газар нутаг, засаг захиргааны бүрэн бүтэн байдлыг хадгалах үндсэн дээр их гүрнүүд ижил нөхцлөөр Хятадад нэвтрэх тухайд явуулсан «нээлттэй хаалга»-ны бодлого 1945 оны холбоотон гурван гүрний тэргүүн нарын Ялтын бага хурлын үеэр байгуулсан нууц хэлэлцээрээр Гадаад Монголын (БНМАУ) status quo-г хүлээн зөвшөөрснөөр төгсгөл болсон юм.

Хоёрт: «Гуравдагч» гүрнүүдтэй холбоо харилцаа тогтоох чинхүү эрмэлзэл тодорхой үр дүнд ч хүрчээ. 1920-иод оны эхнээс Ваймерын Бүгд Найрамдах Улс Монгол Улсыг олон улсын эрхзүйн ад hoc хэлбэрээр хүлээн зөвшөөрсөн гэж үзэж болохоор байна. Улс буюу Засгийн газрын хооронд бие биеэ харилцан хүлээн зөвшөөрөөгүй, үл зөвшөөрөх ноцтой учир шалтгаантай боловч тодорхой нэгэн асуудлыг шийдвэрлэхийн тулд түр зуур албан ёсны харилцаанд орох тохиолдол олон улсын харилцааны түүхэнд түгээмэл байсан бөгөөд одоо ч байгаа юм. Үүнийг дипломатын болон олон улсын эрхзүйд ад hoc хүлээн зөвшөөрөх гэх агаад ад hoc хүлээн зөвшөөрснөөр тухайн тохиолдлын хүрээнээс хэтэрсэн эрхзүйн үр дагавар үл гардаг байна. 1920-иод онд Монгол-Германы худалдаа-эдийн засгийн харилцаа амжилттай, 1930-аад оноос зохих түвшинд хөгжиж, Монголын удирдагчид Герман улстай харилцаагаа худалдаа, соёлын салбарт хөгжүүлэх талаар бие даасан, идэвхтэй байр суурь баримталж байсныг онцлон тэмдэглэвэл зохино.

Монгол Улсыг ад hoc хүлээн зөвшөөрсний өөр жишээ нь 1921 оны 4 дүгээр сарын 1-нд Гадаад Монголыг тусгайлан хариуцсан АНУ-ын анхны суурин Консулын төлөөлөгчийн газар Чуулалт-Хаалган хотноо нээгдэж, шинээр томилогдсон консул Самуэл Сокобин бээр энэ албыг хашиж байсан хугацаандаа Өргөөд дөрвөн ч удаа ирж байсан ба анхны аялалаараа л гэхэд нийслэл Хүрээнд нэг сар байж, Ардын Засгийн газрын Ерөнхий сайд бөгөөд Гадаад хэргийн тэргүүн сайд Д.Бодоо бусад сайд нар, Хэмжээт эрхт хаан VIII Богд Жавзундамба хутугт

зэрэг өндөр албаны хүмүүстэй уулзаж худалдааны болон албан ёсны харилцаа тогтоох яриа хэлэлцээ явуулж байсныг АНУ-ын эх сурвалж нотолж байна. Гуравт: 1922-1928 он хүртэл Монгол Улсаас Өрнөдийн орнуудтай эдийн засгийн гадаад харилцааг үүсгэн хөгжүүлэхэд ЗХУ эхэндээ нэлээд нааштай хандаж байсныг эх сурвалж харуулж байна. Учир нь 1920-иод оны дунд үе гэхэд ЗХУ нэр хүнд олон улсын тавцанд өсгөж чадсан бөгөөд Өрнөдийн 20 гаруй орон тус улсыг хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтоосны дотор Англи, Итали, Герман, Австри, Грек, Турк, Дани, Норвеги, Швед, Финлянд, Франц зэрэг орон байв. Тиймээс ч ЗХУ Өрнөдийн орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаагаа идэвхтэй өргөжүүлэн хөгжүүлж эхлээд байжээ. Нөгөө талд Өрнөдийн капиталист орнуудын эдийн засаг Дэлхийн I дайны дараа анх удаа түр тогтворжилын үедээ [1925-1929 он] ороод байсан юм.

Гэхдээ Өрнөдийн орнуудтай харилцаагаа тогтоон хөгжүүлэхийг эрмэлзсэн гол санаачлагч нь Монголын улс төрийн удирдагчид байсан гэдгийг эх сурвалж нотолж байна. Үүнд: 1923 онд баталсан Эдийн засгийн үндсэн бодлого баримт бичиг онцгой байр эзэлнэ. Тэр үед нам, төрийн удирдлагад ажиллаж байсан зарим зүтгэлтэн аж ахуйг зах зээлийн харилцаан тулгуурлан, эдийн засгийн сонирхол дээр хөтлөн явуулах, үндэсний хөрөнгөлөг этгээд, гадаадын капитал, пүүсүүдийг эдийн засгийг хөгжүүлэхэд идэвхтэй ашиглах, капиталист орнуудтай худалдааны хүрээнд хамтран ажиллах, хөрөнгөтөн орнуудад оюутан сургах, ер нь нийгмийн байгуулалын ялгааг үл харгалзан нийт хүн төрөлхтөний үнэт зүйлсээс суралцах нь чухал ач холбогдолтой гэж үзэж байжээ.

Дөрөвт: 1930 оны 12 дугаар сард ЗХУ-ын гардан оролцоотойгоор гадаад худалдаанд улсын онц эрх (монополия) тогтоосноор Монгол Улс нэг улсаас эдийн засаг, улс төрийн талаар хараат болохын эх үндэс тавигдсан байна. Энэ тухай бүр 1950-аад оны сүүлээр Америкийн эрдэмтэн Р.Рупены өөрийн бүтээлдээ 1930-аад оны эхэн гэхэд БНМАУ Зөвлөлтийн тойрог замд нэгэнт орж дагуул улс болсон гэж дүгнэсэн байдаг. Дээрх үйл явц цаашдаа БНМАУ-ын эдийн засаг-улс төрд ноцтой хор уршиг тарьсан нь тодорхой болсон билээ. Харин ЗХУ-д үйлдвэрлэдэггүй бараа бүтээгдэхүүнийг Зөвлөлтийн нутгаар

дамжуулан Монголд оруулж ирэх үүднээс ганцхан Германы «Востваг» компаний Монголд явуулах үйл ажиллагааг зөвшөөрчээ.

Ер нь Монголоос Өрнөдтэй харилцах харилцаанд Зөвлөлт-Хятадын 1924 оны 5 дугаар сарын 31-ний хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн заалт хамгийн том саад болж байжээ. 1921-1945 он хүртэл Гадаад Монголын (БНМАУ) олон улсын эрхзүйн статус олон улсын хэмжээнд хоёрдмол ойлголтыг буй болгож байсан нь 1921 оны 11 дүгээр сарын 5-нд Москвад гарын үсэг зурсан «Монгол, Оросын хооронд найрамдлын барилдлагааг байгуулах тухай Монголын Ардын Засгийн газар ба Зөвлөлийн Засагт Орос Улсын Засгийн газрын хэлэлцэн тогтоосон гэрээ бичиг», 1924 оны 5 дугаар сарын 31-нд Бээжинд гарын үсэг зурсан «ЗСБНХУ, Хятадын БНУ-ын хоорондын харилцааг зохицуулах Ерөнхий зарчмын тухай хэлэлцээр»-тэй шууд холбоотой байв. 1921 оны Москвагийн гэрээ бичгийн 1 дүгээр зүйлд Зөвлөлт Орос Улсын Засгийн газар Монголын Ардын Засгийн газрыг хууль ёсны цорын ганц Засгийн газар хэмээн хүлээн зөвшөөрч, 4, 5 зүйлд дипломат ба консулын төлөөлөгч харилцан солилцохоор тогтсон юм. Гэтэл 1924 оны Бээжингийн хэлэлцээрийн 5 дугаар зүйлд “ЗСБНХУ-ын Засгийн газар Гадаад Монгол нь Хятадын БНУ-ын салшгүй бүрэлдэхүүн хэсэг учир тэнд Хятадын БНУ-ын бүрэн эрхийг хүндэтгэнэ” гэж заажээ. Энэ нь Зөвлөлт Засгийн газар нь Хаант Оросын байр сууринаас ч доошилсон хэрэг болсон билээ. БНМАУ-ын олон улсын статусын хоёрдмол ойлголт 1945 оны Ялтын хэлэлцээр, Зөвлөлт-Дундын найрамдал, холбоотны гэрээгээр нэг мөр цуцлагдаж, 1949 оны ЗСБНХУ ба БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох үеэр солилцсон ноот бичгээр дахин баталгааж, 1961 онд БНМАУ НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болсноор түүний олон улсын эрхзүйн статус de jure эцэслэн шийдвэрлэгдсэн юм.

1911 оноос 1930 он хүртэлх 20 гаруй жилийн түүх бол Монголын орчин цагийн түүхийн Renaissance буюу сэргэн мандалтын үе байсан гэж дүгнэж болохоор байна.

ЭШЛЭЛ ЗҮҮЛТ

1. УТТА. ФА-4, Д-1, ХН-5
2. Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл.”1910-1914”, УБ., 1982, 61 дэх тал
3. УТТА. Ф-4. ХН-658. Б-2. Монгол-Түвдийн 1913 оны Гэрээ бичиг
4. Үндэсний түүхийн музейн архив. Ж. Цэвээний холбоотой материалууд. №11
5. Монголын Автономитын үеийн сургууль. Баримт бичгийн эмхтгэл. УБ.,1966, №67. 74. 109, 124 дэх тал
6. Мөн тэнд
7. Хейфец А.Н. Советская дипломатия и народы востока. 1921-1927. М., 1968, с. 81
8. «Mongolia Speaks to the World. Chairman of the Council of Ministers and Minister for Foreign Affairs of Mongolian People’s Government Mr. Bodo»-Journal: “The Nation” NY.: Vol. CXIII, Wednesday, November 13, 1921 Campi A.J, Baasan R. The Impact of China and Russia on United States- Mongolian Political Relations in the Twentieth Century. Lewiston, NY: The Edwin Mellin Press, 2009, p. 85
9. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. (1921-1961) Боть I, УБ.: 1964, 4 дэх тал
10. Bundesarchiv, (Barch,R-9208/2407/235-2361), BL. 174-177
11. Bundesarchiv, (Barch,R-9208/2359/2360-2361), BL. 177, 299
12. ХБНГУ-ын Бундес архивт буй Монголын тухай баримт сэлт “КЕМУ” сэтгүүл. 2005 №1 (09) 15-20 дахь тал
13. Мөн тэнд
14. “Эдийн засгийн үндсэн бодлого”. Нийслэл Хүрээ 1923.7.23. УТТА. Лавлах номын сан, 3/2330-ын 7-8 дахь тал
15. Б.Лхамсүрэн. Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол. УБ., 1995, 44 дэх тал

16. “Эдийн засгийн үндсэн бодлого”. Нийслэл Хүрээ 1923.7.23.
ҮТТА. Лавлах номын сан, 3/2330-ын 7-8 дахь тал
17. ГХТА. Ф.01. ХН.1173
18. ГХТА. Ф.01. ХН274
19. Serge M. Wolff. «Mongol Delegations in Western Europe, 1925-1929», Part II, The Journal for Royal Central Asiatic Studies, 1945. Vol, XXXII, pp.75-93, Part III, IV, July-October, 1945, pp.289-298
20. ҮТТА.Ф.172. Т.5.ХН.98
21. ҮТТА.Ф.91. Т.27. ХН.12
22. ҮТТА.Ф.91. Т.27. ХН.13-14
23. ГХТА. Ф-62.ХН-62. “Монгол ба Тагна-Тыва хоёрын хооронд Найрамдлын Холбоо байгуулах тухай Гэрээ бичиг”. 1926.08.16
24. Д.Уламбаяр. «БНМАУ Тагна-Тыватай дипломат харилцаа тогтоосон нь, түүний түүхэн учир холбогдол». “Олон улс судлал” сэтгүүл. ОУСХ, ШУА, 2008. №4, 88-94 дэх тал
25. Ц.Батбаяр. Монгол ба Их гүрнүүд XX зууны эхний хагаст. Хиагтаас Ялта хүртэл. УБ., 2006, 140-166 дахь тал
26. «Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Холбоот Улс ба БНМАУ хоёрын хоорондын үндсэн зүйлүүдийг батлан тогтоосон Гэрээ бичиг» ГХТА. Хөмрөг №119, Д. 1. ХН. 0212813 16, Д.Уламбаяр. Монгол Улс, Алс Дорно дахин: Олон улсын харилцаа, геополитик, дипломат ажиллагаа. (XX зууны эхнээс XXI зууны эхэн) Тэргүүн боть, УБ., 2013, 367-373 дахь тал